

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дүгээр хавсралт

БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ДАРГА ЭРДЭНЭХҮҮГИЙН ЛХАГВАСҮРЭНГИЙН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт																																						
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь																													
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)																																	
					1	2	3																															
					5			6	7																													
Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах																																						
1.	Хууль ёсны гадаад худалдааг хөнгөвчлөх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ	Хэрэгжилт, хувиар, гүйцэтгэлээр	-	1. Худалдааг хөнгөвчлөх чиглэлээр гарсан бодлогын баримт бичиг, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, бараагаа өөрөө мэдүүлэх үйл ажиллагааг нэмэгдүүлэх, санал боловсруулан танилцуулсан байна. 2. Бичиг баримтын бүрдүүлэлтэд зарцуулсан дундаж цаг	1. Тайлант хугацаанд импортын гаалийн бүрдүүлэлт 36.2 хувиар өссөн бөгөөд импортын гаалийн мэдүүлгийн хяналтын төлөвт биет шалгалтаас чөлөөлөгдөх хувь буурсан байна.				2024.01.01-2024.06.10																													
					<table><tr><td rowspan="2">Төлөв</td><td colspan="2">2023 оны эхний хагас жил</td><td colspan="2">2024 оны эхний хагас жил</td></tr><tr><td>Тоо</td><td>Хувь</td><td>Тоо</td><td>Хувь</td></tr><tr><td>Ногоон</td><td>5,627</td><td>3.9%</td><td>7,045</td><td>3.6%</td></tr><tr><td>Улбар шар</td><td>25,306</td><td>17.7%</td><td>25,096</td><td>12.8%</td></tr><tr><td>Улаан</td><td>112,033</td><td>78.4%</td><td>162,705</td><td>83.6%</td></tr><tr><td>Нийт</td><td>142,966</td><td></td><td>194,846</td><td></td></tr></table>					Төлөв	2023 оны эхний хагас жил		2024 оны эхний хагас жил		Тоо	Хувь	Тоо	Хувь	Ногоон	5,627	3.9%	7,045	3.6%	Улбар шар	25,306	17.7%	25,096	12.8%	Улаан	112,033	78.4%	162,705	83.6%	Нийт	142,966		194,846	
					Төлөв	2023 оны эхний хагас жил		2024 оны эхний хагас жил																														
						Тоо	Хувь	Тоо		Хувь																												
					Ногоон	5,627	3.9%	7,045		3.6%																												
Улбар шар	25,306	17.7%	25,096	12.8%																																		
Улаан	112,033	78.4%	162,705	83.6%																																		
Нийт	142,966		194,846																																			
				Гэсэн хэдий ч БЦТ-өөс Нефть импортлогчид, хүнсний импортлогчид, Япон улсаас суудлын автомашин импортлогч аж ахуйн нэгж, иргэн, мэдүүлэгч байгууллагуудыг зөвшөөрөгдсөн, үл хамаарах шалгууруудад хамруулах саналыг, судалгааны хамтаар 3 удаагийн дотоод зурвасаар хүргүүлж ажилласан. Ногоон төлөвт сонгогдсон гаалийн бүрдүүлэлтийн тоо өмнөх оны мөн үеэс 1.2 дахин буурсан нь нийт мэдүүлгийн тоо өмнөх оны мөн үеэс 51,880 гаалийн мэдүүлгээр их байгаатай холбоотой.																																		
				<table><tr><td rowspan="2">Төлөв</td><td colspan="2">2023 оны хагас жил</td><td colspan="2">2024 оны хагас жил</td></tr><tr><td>Үнэлсэн барааны тоо</td><td>Хувь</td><td>Үнэлсэн барааны тоо</td><td>Хувь</td></tr><tr><td>1-р арга</td><td>670,684</td><td>77,8%</td><td>738,692</td><td>74,5%</td></tr></table>				Төлөв	2023 оны хагас жил		2024 оны хагас жил		Үнэлсэн барааны тоо	Хувь	Үнэлсэн барааны тоо	Хувь	1-р арга	670,684	77,8%	738,692	74,5%																	
Төлөв	2023 оны хагас жил		2024 оны хагас жил																																			
	Үнэлсэн барааны тоо	Хувь	Үнэлсэн барааны тоо	Хувь																																		
1-р арга	670,684	77,8%	738,692	74,5%																																		

			хугацааг өмнөх оны мөн үеэс 1,5 хувиар бууруулсан байна.	Бусад арга	191,967	22,2%	254,057	25,5%																												
			3. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт, хөгжүүлэлтийн саналыг тухай бүрт нь гарган, МТТ-д хүргүүлсэн байна.	Гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалтын явц дахь үнэлгээний аргаар авч үзэхэд 2023 оны эхний хагас жилийн нийт барааны 77.8 хувийг хэлцлийн аргаар үнэлж байсан бол тайлант хугацаанд энэ хувь 74,5 хувь болон буурсан. Гаалийн байгууллагаас гаалийн бүрдүүлэлтийг цахимаар хийхээр зориулагдсан www.gaali.mn флатформыг ашиглан гаалийн байгууллагад мэдүүлсэн байдал өнгөрөгч оны тайлант хугацаанд 134,001 буюу нийт импортын бичлэгийн 15.5 хувийг эзэлж байсан бол тайлант хугацаанд 160,037 буюу нийт импортын бичлэгийн 16.1 хувийг эзэлж эзлэх хувиар болон нийт тооны хэмжээ нь өссөн эерэг үр дүн гарч байгаа ба цаашид ч уг тоо өсөх боломжтой юм. Бүрдүүлэлтийн цахим төвд импортын барааны гаалийн бүрдүүлэлт хийгдэж төвлөрсөн нийт татварын 12.3 хувийг цахимаар өөрөө мэдүүлсэн аж ахуйн нэгжийн бараанаас төвлөрсөн. Өмнөх оны цахимаар өөрөө мэдүүлсэн мэдүүлгийн тоо 34.7 хувиар, нийт мэдүүлэгт эзлэх хувьтай харьцуулвал 1 хувиар тус тус өссөн. <i>Хүснэгт №1</i> <table><tr><th colspan="2">Үзүүлэлт</th><th>Мэдүүлгийн тоо</th><th>Татварын дүн тэрбум төгрөг</th></tr><tr><td rowspan="3">2023 он</td><td>Нийт</td><td>143,647</td><td>2,330.45</td></tr><tr><td>Цахимаар өөрөө мэдүүлсэн</td><td>11,257</td><td>276.24</td></tr><tr><td>Эзлэх хувь</td><td>7.84</td><td>11.85</td></tr><tr><td rowspan="3">2024 он</td><td>Нийт</td><td>198,143</td><td>2,972.16</td></tr><tr><td>Цахимаар өөрөө мэдүүлсэн</td><td>17,238</td><td>366.48</td></tr><tr><td>Эзлэх хувь</td><td>8.7</td><td>12.3</td></tr><tr><td colspan="2">Өссөн хувь</td><td>1</td><td>0.5</td></tr></table> Тайлант хугацаанд 2328 аж ахуйн нэгж иргэн 160,024 барааны 17,238 мэдүүлгийг цахимаар мэдүүлэн 366.48 тэрбум төгрөгийн барааг улсын төсөвт төвлөрүүлсэн. Цахимаар өөрөө мэдүүлсэн аж ахуйн нэгжүүдийн гадаад худалдаанд оролцож буй байдлыг үзвэл 2024 онд 2009 буюу 86.3 хувь, 2023 онд 1158 буюу 81.6 хувийг гаалийн байгууллага ГТГТХ-ийн 8.3-р зүйлд зааснаар импортын барааны хэлцлийн үнийн аргаас татгалзаж үнэлгээний бусад аргаар үнэлж 21 тэрбум төгрөгийн гаалийн болон бусад татварыг улсын төсөвт нэмж төвлөрүүлсэн байна. Цахимаар өөрөө мотоцикл, хувцас, сэлбэгийг хамгийн их мэдүүлсэн байна. Цахимаар өөрөө хамгийн их мэдүүлсэн 10 ААН, иргэн нийт өөрөө мэдүүлсэн мэдүүлгийн ногдуулсан татварын 43.7 хувийг, мэдүүлгийн 28.3 хувийг тус тус эзэлж өмнөх оноос бүрдүүлэлтийн тоо нь өссөн байна. Үүнээс Барло ворлд монголиа ХХК /ГХО/ нь өмнөх оноос мэдүүлгийн тоо 19.5 хувиар өсч, нийт өөрөө мэдүүлсэн эдүүлгээр төвлөрүүлсэн татварын 15.4 хувийг эзэлж байна. Өөрөө мэдүүлсэн мэдүүлгийн 23 хувь засварт буцаж, импортын барааны гаалийн нийт мэдүүлгийн өөрчлөгдсөн талбарын 56.4 нь өөрөө мэдүүлсэн импортлогч өөрчлөн илгээсэн байна. Тээврийн зардал, Хэлцлийн нэгж үнэ, Гаалийн нэгж үнэ (USD), Нэмэгдэх зардал гэсэн статистик дүн үнэтэй холбоотой талбаруудыг засварт буцаахад хамгийн өөрчилсөн байгаа нь цахимаар өөрөө мэдүүлсэн аж ахуйн нэгж иргэд гаалийн мэдүүлэгт барааны үнэ нэмэгдэх зардлыг оруулж чадахгүй байгаа нь харагдаж байна. Үүнээс харахад цахимаар өөрөө хийсэн тохиолдолд нэгж үнийг алдах магадлал өндөр байгаа нь харагдаж байгаа тул программын түвшинд гаалийн бүрдүүлэлтийн горимтой уялдуулан тохиргоог хийх шаардлага үүсч байна.					Үзүүлэлт		Мэдүүлгийн тоо	Татварын дүн тэрбум төгрөг	2023 он	Нийт	143,647	2,330.45	Цахимаар өөрөө мэдүүлсэн	11,257	276.24	Эзлэх хувь	7.84	11.85	2024 он	Нийт	198,143	2,972.16	Цахимаар өөрөө мэдүүлсэн	17,238	366.48	Эзлэх хувь	8.7	12.3	Өссөн хувь		1	0.5
Үзүүлэлт		Мэдүүлгийн тоо	Татварын дүн тэрбум төгрөг																																	
2023 он	Нийт	143,647	2,330.45																																	
	Цахимаар өөрөө мэдүүлсэн	11,257	276.24																																	
	Эзлэх хувь	7.84	11.85																																	
2024 он	Нийт	198,143	2,972.16																																	
	Цахимаар өөрөө мэдүүлсэн	17,238	366.48																																	
	Эзлэх хувь	8.7	12.3																																	
Өссөн хувь		1	0.5																																	

				2. Гаалийн бүрдүүлэлт дэх бичиг баримтын шалгалт хийхэд зарцуулагдсан цаг хугацааг 2023 оны хагас жилийн тайлант хугацаанд бичиг баримтын шалгалтад зурцуулсан дундаж хугацаа "ногоон" төлөвт нэгж бараанд 26 минут, "улбар шар" төлөвт 49 минут, "улаан" төлөвт 43 минут, нийт дундаж хугацаа нэгж бараанд 43 минут байна. 2024 оны тайлант хугацаанд бичиг баримтын шалгалтад зарцуулсан хугацаа "ногоон" төлөвт нэгж бараанд 11 минут, "улбар шар" төлөвт 30 минут, "улаан" төлөвт 33 минут, нийт дундаж хугацаа нэгж бараанд 32 минут байна. Бичиг баримтын шалгалт хийхэд нэгж бараанд зарцуулсан хугацааны дунджийн өөрчлөлтийг төлөв тус бүрээр авч үзэхэд тайлант хугацаанд "ногоон" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 54.9 хувиар, "улбар шар" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 39.3 хувиар, "улаан" төлөвийн нэгж барааг шалгах хугацаа 21.5 хувиар, нийт нэгж бараанд хийх шалгалтын хугацаа 25.5 хувиар буюу 11 минутаар буурсан буюу бичиг баримтад хийх шалгалтын хугацаа буурсан байна. Бичиг баримтын шалгалтад зарцуулах цаг хугацааг буурахад Бүрдүүлэлтийн цахим төвөөс Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй хамтран хяналтын төлөвийг улбар шар, ногоон гаргах боломжуудыг нэмэгдүүлэх, тэдгээр төлөвт лабораторийн дүгнэлтгүйгээр бичиг баримтын шалгалт хийх, зарим барааны бүлгээр гаалийн улсын байцаагч нарыг дагнан бичиг баримтын шалгалт хийх боломжийг бүрдүүлэх ажлыг мөн Мэдээллийн технологийн газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн, мөн гаалийн улсын байцаагч нар нэгдсэн байдлаар шийдвэр гаргаж, тогтмол хяналттайгаар ажиллаж байгаа зэрэг зүйлс нөлөөлсөн гэж үзэж байна. 3. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр дараах саналыг гарган ГЕГ-ын Мэдээллийн технологийн газарт дотоод зурвасаар 3 удаа нийт 23 санал, үйл ажиллагааг хялбарчлах, програмын сайжруулах талаар саналыг тухай бүрт нь гаргаж хүргүүлсэн байна. Үүнд: - Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийн сайжруулалт, өөрчлөлт, хөгжүүлэлтийн саналыг БЦТ-өөс гаалийн бүрдүүлэлт дэх бичиг баримтын шалгалттай уялдуулан гаргаж байгаа бөгөөд энэ хүрээнд ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, гаалийн үнийн хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор 8703, 8704-т хамаарах суудлын болон ачааны автомашин, зарим төрлийн чиргүүл, зарим төрлийн хүнд машин механизмын бичиг баримтын шалгалтыг барааны бүлгээр ангилах ажлыг санаачлан МТГ-тай хамтран хэрэгжүүлж эхлээд байна. - Гаалийн бүрдүүлэлтийг боловсронгуй болгох, үнийн хяналтыг цахимжуулах ажлын хүрээнд Япон улсаас импорлож байгаа суудлын автомашины үнийн судалгаа хийсэн. Судалгаа дүн шинжилгээний үндсэн импортын суудлын автомашины гаалийн үнэлгээг автоматжуулах ажлыг ГЕГ-ын БАҮХ, МТГ-тай хамтран эхлүүлэн програмын туршилтыг хийсэн. Програмыг нэвтрүүлснээр CAIS системээс мэдүүлгийг бичиг баримтын шатанд автоматаар холбогдох шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан хянаж, тухайн иргэн, ААН-ийн гэрээний буюу элцлийн үнийг үндэслэн гаалийн үнийг тодорхойлох боломжтой болох юм. - Caïs системийн татварын хувь хэмжээ-үнийн мэдээллийн сан-мэдүүлгийн бичлэг-эвдрэлтэй-тийм гэсэн сонголт идэвхижэхгүй байсныг ГЕГ-ын Мэдээлэл технологийн хэлтэстэй холбогдож засуулсан. Дотоод зурвасаар санал хүргүүлсэн байдал: - CAIS програмын зөрчил цэсэнд ГЕГ-БЦТ гэсэн сонголтыг нэмүүлэх саналыг 2024.03.21-ний өдрийн №39 тоот дотоод зурвасаар Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. - CAIS, CEPS системд оруулах 20 өөрчлөлтийн талаарх саналыг 2024.05.09-ны өдрийн №62 тоот дотоод зурвасаар - ГУБ, ГУАБ нарт кайс програмд ажиллах эрх нээлгэх тухай хүсэлтийг 2024.05.20-ны өдрийн №65 тоот дотоод зурвасаар тус тус хүргүүлэн ажилласан байна.	
--	--	--	--	---	--

2.	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаа	Хэрэгж илт, гүйцэтг элээр	1. Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. 2. ГБМ-ний үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж, улирал бүр /нийт 2 удаа/ засварт буцаалтад судалгаа, дүн шинжилгээ хийж, санал гарган БАҮХ-т хүргүүлсэн байна.	"Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын төсөлд гаргасан саналыг 2024.04.01-ний өдрийн №46 тоот дотоод зурвасаар Барааны ангилал, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. 2024 оны эхний хагас жилийн мэдүүлгийн алдаа, мэдүүлгийн засварт буцаалт: Бүрдүүлэлтийн цахим төв нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар гаалийн ерөнхий газрын харьяа газар, хорооны хэмжээнд 199806 импортын, 367975 экспортын, нийт 567781 гаалийн мэдүүлгийн 1404210 бичлэгээр гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. Тайлант хугацаанд нийт 989 гаалийн зуучлагч аж ахуйн нэгж, байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн болон зуучлагчид 41989 буцаасан байна. Гаалийн зуучлагч байгууллагын мэдүүлгийн засварт буцаалтыг авч үзвэл нийт 41989 удаагийн засварт буцаалт байгаагаас дагалдах баримт нэмсэн 4638 засварт буцаалтыг хассанаар 37351 бичлэг засварласан байна. Гаалийн мэдүүлэг нь гадаад худалдааны болон татварын холбогдолтой статистикийн мэдээллийг гаргах үндсэн аж сурвалж болдог. Мэдээллийн санг зөв бүрдүүлэх үүднээс гаалийн бүрдүүлэлт дууссан буюу мэдүүлэг баталгаажсаны дараа гаалийн мэдээллийн санд алдаатай бүртгэгдсэн мэдүүлгийг буцааж засварлах үйл ажиллагаа хийгдэж, Гаалийн Ерөнхий Газрын даргын 2016 оны А/82 тоот тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар"-ын 1 дүгээр хавсралт /Мэдүүлгийг засварт буцаах хүсэлтийн кодчилсон жагсаалт/-ын дагуу засварт буцаан ажиллаж байна. Гаалийн мэдүүлэгч байгууллагууд болон гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд хийсэн сургалтуудын талаар: - 2024 оны I улиралд Бүрдүүлэлтийн Цахим Төвийн ГУАБ Ө.Пунсалдулам, II улиралд Бүрдүүлэлтийн Цахим Төвийн ГУАБ Ц.Бурмаа нар гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтад гаалийн бүрдүүлэлтийн цахим төвийн танилцуулга болон Гаалийн Ерөнхий Газрын даргын 2016 оны А/82 тоот тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг нөхөн бичих заавар" болон холбогдох бусад хууль тогтоомжийг танилцуулсан сургалт зохион байгуулсан. - 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдөр гаалийн зуучлагч аж ахуйн нэгж, байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн болон зуучлагч нарт Гаалийн Бүрдүүлэлтийн Цахим Төвөөс "Гаалийн бүрдүүлэлтэнд анхаарах асуудлууд" сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус цахим сургалтанд 100 гаруй итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн 200 орчим гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн зуучлагч нар хамрагдсан. Гаалийн мэдүүлэг болон засварт буцаасан бичлэгийг 2023, 2024 онуудаар харьцуулан харахад: 2023 оны эхний хагас жилд 426966 гаалийн мэдүүлгээр 1171709 бичлэгийг хянаж, 33400 бичлэг засварт буцаасан нь нийт бичлэгийн 2,9% эзэлж байсан бол 2024 оны эхний хагас жилд 567781 гаалийн мэдүүлгээр 1404210 бичлэгийг хянаж 41989 бичлэгийг засварт буцаасан нь нийт бичлэгийн 3% эзэлж байгааг харьцуулбал мэдүүлгийн тоо 140815, бичлэгийн тоо 232501, засварт буцаалт 0,1% өсөлттэй харагдаж байна. Гаалийн бүрдүүлэлтийн явцад гарсан зөрчлийг шалган шийдвэрлэсэн талаар: Тайлант хугацаанд гаалийн мэдүүлгийн баазыг үнэн зөв бүрдүүлэх, гаалийн болон бусад татварыг хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв ногдуулж барагдуулах зорилгоор бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад гарсан алдааг цаг тухайд нь залруулж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад таван гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэний гаргасан зөрчилд зөрчилийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авсан. Эхний хагас жилийн байдлаар 9 ГБМ захиргааны арга хэмжээ авч 2700000 төг торгууль оногдуулсан. Гаалийн бүрдүүлэлтийн явцад гарч буй алдааг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар: Бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад гарч буй алдаанд дүн шинжилгээ хийж, тухайн төрлийн алдааг	2024.01.01-2024.06.10	
----	--	---------------------------	--	---	-----------------------	--

					бууруулах, цаашид давтан гаргуулахгүй байх чиглэлээр дараах сэдвээр гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. Үүнд: - Экспорт, импортын болон улс хооронд дамжин өнгөрүүлэх бараанд хийх гаалийн бүрдүүлэлт; - Гаалийн горим, горимын ангилал, төрөл, горимын нөхцөл шаардлага; - Барааг гаалийн зорилгоор таних, тодорхойлох, кодлох; - Экспорт, импортын барааны гаалийн үнэ, түүнийг тодорхойлох үндсэн арга; - Гаалийн үнэ ба Инкотермс; Барааны гарал үүслийг тодорхойлох; - Гаалийн татвар, гаалийн тариф, тарифын бус зохицуулалт; - Экспорт, импортын барааг дагалдах гадаад худалдааны бичиг баримт, гаалийн бүрдүүлэлтэд түүний ач холбогдол; - Гадаад худалдааны гэрээ, түүний нөхцөл, барааг гаалийн байгууллагад мэдүүлэхэд шаардагдах мэдээлэл; Мэдүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага; - Гаалийн мэдүүлэг нөхөн бичих, CEPS системд ажиллах.		
3.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Сургалт зохион байгуулах 2. Заавал шалгах, өндөр эрсдэлийн шалгуурууд болон хяналт шалгалтаас чөлөөлөх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийг сар бүр 5-аас доошгүй ААН, иргэн, бараагаар хийж, ЭУХ-т хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд: 1. Алба хаагчдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон 2024 оны сургалт зохион байгуулж, хамрагдсан байдал: Дотоод сургалт: Ажлын долоо хоногийн Мягмар гараг бүр өглөө 08.00 цагаас "Мэдээллийн цаг"-ийг тогтмол хийж, алба хаагч нар ээлжлэн нийт бичиг баримт хариуцсан ГУБ нарт гаалийн бүрдүүлэлт болон тухайн цаг үед бий болсон асуудлаар сургалт, мэдээлэл өгөн ажиллаж байна. Ингэхдээ нийт алба хаагч нарын ирцийг бүртгэн, төвийн даргаас алба хаагч нарт анхаарах асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгч байна. Гадаад сургалт: АНУ-д зохион байгуулагдсан сургалтад ГУБ 1, Япон улсад зохион байгуулагдсан сургалтад 1 ГУАБ, 2 ГУБ нар хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлэн ажилласан байна. Бусад: Оюуны өмч, Гарал үүсэл, Гаалийн имтгэмжлэгдсэн ААН-ийн чиглэлээр 11 ГУБ хамрагдаж мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн байна. Мөн ГЕГ-ын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2024.05.12-17-ны өдрүүдэд БАҮХ, ЗҮТГ-ын Гаалийн бүрдүүлэлтийн албаны албан хаагч нар болон МҮХАҮТ-ийн төлөөллийн хамт БНХАУ-ын Эрэн, Бугат хотын барилгын материал, төмөр, төмөр хийц, хүнд машин механизм, тоног төхөөрөмж, ачааны автомашины үнийн судалгаа хийхэд оролцсон. Ажлын хэсэг 206 нэр төрлийн барааны үнийн судалгааг нэгтгэхэд оролцон 0320240300002 дугаартай хавтсанд байршуулан үнийн судалгааг 2024.06.04-ний өдрөөс эхлэн үнэлгээний зорилгоор ашиглаж байна. 2. 2024.06.17-ны өдөр БЦТ-ийн бичиг хэргийн албан тушаалд шинээр Ц.Мөнхболор томилогдсон. 2024 оны 1 дүгээр улиралд 2024 онд хөтлөгдөж дууссан баримтыг чиглэл тус бүрээр хүлээн авах хуваарийг гаргаж, хуваарийн дагуу бүрэн архивласан. 2024 оны эхний хагас жилд үүссэн 4 чиглэлээр 16 хавтас архивын нэгж үүсгэсэн баримтыг задалж харуулбал: • Дотоод зурвас 1 хавтас • Албан бичиг 1 хавтас • Ирсэн хүсэлт 1 хавтас • БТКУС-ын шийдвэрийн 13 хавтас 3. Бүрдүүлэлтийн цахим төвийн чиг үүргийн хүрээнд ААН-үүдэд судалгаа хийж, хууль сахилт сайн 19 ААН-ын эрсдэл тооцож болох мэдээллийг "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийн дагуу 4 удаа гаргаж 2024.02.01-ний өдрийн №5, 2024.04.12-ны өдрийн №52, 2024.05.06-ны өдрийн №58, 2024.05.30-ны өдрийн №72 тоот дотоод зурвасуудаар тус тус ЭУХ-т хүргүүлсэн. 4. Тайлант хугацаанд БББХГУБ нараас нийт 168 ААН-д БДШ оруулах саналыг давхардсан тоогоор 224 удаа кайс програмд оруулсан байна. 9 ААН-ын нэрийг БДШ-д хамруулахаар хүргүүлсэн.	2024.01.01-2024.06.10	
4.	Гаалийн байгууллаг	Хэрэгжилт,	-	Нэгжийн чиг үүргийн	Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд БЦТ-өөс тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажиллалаа.	2024.01.01-	

ын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагаан ы төлөвлөгөө ний хэрэгжилт йг хангах	гүйцэтг элээр	хүрээнд төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Төлөвлөгөөний 2.2-т заагдсан ажлын хүрээнд: - 2024 оны 04-р сарын 03-ны өдөр Бүрдүүлэлтийн цахим төвийн ГУАБ Ө.Пунсалдулам, О.Шагдар нар гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан сургалтад "Гаалийн үнэ, үнэлгээ", "Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний үйл ажиллагаанд анхаарах асуудал" сэдвээр сургалт хийж тус сургалтын хүрээнд гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний алдаа, түүнд авах арга хэмжээ, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар мэдээлэл өгсөн. - Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан хүсэлтийн дагуу 2024 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албан хаагч нарт "Гаалийн байгууллагын гаалийн бүрдүүлэлтэй холбоотой" сэдвээр Бүрдүүлэлтийн цахим төвийн гаалийн улсын байцаагч Н.Монгол-Ордэнэ мэдээлэл өгч байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан. - 2024.05.09-ны өдөр Гаалийн зуучлагчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журмын"-ыг шинэчлэн боловсруулах хэлэлцүүлэгт ГУАБ Шагдар, Бурмаа, Алтантуяа нар оролцож санал бодлоо солилцсон. Төлөвлөгөөний 2.4-т заагдсан ажлын хүрээнд: - Тус төвийн үйл ажиллагаатай холбоотой Засгийн газрын 1111 утас, гаалийн лавлах 1800-1281 утас, БЦТ-ийн 7001280 утас болон tsahimgaali@customs.gov.mn хаягаар ирсэн гомдол, мэдээллийн судалгааг БТКУС хариуцсан баг сар бүр гарган тайлагнаж, удирдлагыг мэдээллээр хангаж хэвшсэн. - 2024 оны эхнээс 2024 оны 6 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд тус төвийн үйл ажиллагаатай холбоотой Засгийн газрын 1111 утсаар ирсэн 35, гаалийн лавлах 1800-1281 утсаар ирсэн 12, БЦТ-ийн 7001280 утсаар ирсэн 4785 дуудлага болон tsahimgaali@customs.gov.mn хаягаар ирсэн 1007 электрон шуудангаар ирсэн гомдол, мэдээлэл, хүсэлт, санал шүүмжлэлийг хүлээн авч тухай бүр нь хариу өгч ажилласан байна. Үүнээс гаалийн үнэ үнэлгээ, барааны ангилалтай холбоотой гомдол 257 ирснийг бүгдийг нь хуулийн хугацаанд, шуурхай, бодитой шийдвэрлэж, шийдвэрийг гомдол гаргагчид цахимаар болон албан бичгээр хүргүүлэн ажилласан. - Дээрх гомдол, мэдээлэл, хүсэлт, санал шүүмжлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд гаалийн үнэлгээг хурдан шуурхай хийлгэх тухай хүсэлт болон татвар өндөр гарсан байна, ижил төрлийн барааг өөр өөр үнээр үнэлж байна гэсэн гомдол дийлэнх хувийг эзэлж байна. Энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна. • барааны бүлгээр нь авч үзэхэд гаалийн бүрдүүлэлтэд харьцангуй өндөр хувийг эзэлдэг 84, 87-р бүлгийн автомашин, тоног төхөөрөмжийн бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагчдыг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулсан. • Гомдол, мэдээллийн түргэн шуурхай хүлээн авч шийдвэрлэх ажлын хүрээнд 70001280 утсан дээр дуудлага хүлээн авах ажилтны тоо нэг байсныг гурав болгож нэмэгдүүлсэн. • Мөн иргэд, олон нийтэд мэдээллийг хүнд сурталгүй түргэн шуурхай хүргэх ажлыг сайжруулах чиглэлээр гаалийн лавлах 18001281 утсыг тус төвийн 70001280 утастай холбосон. Бүрдүүлэлтийн цахим төвд хамааралтай нийт 274 гомдол ирсэнийг бүгдийг нь хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Үүнд: Гаалийн лавлах 1800-1281 утсанд: Гомдол-3, Засгийн газрын 11-11 утсанд: Гомдол-14 Цахим бүрдүүлэлтийн төвийн 70001280 утсанд: 257 гомдол, 4 санал, 405 хүсэлт, 1 шүүмжлэл, асуулт лавлагаа 194 нийт 861 дуудлага мэдээлэл	2024.0 6.10	
---	------------------	---	--	----------------	--

					хүлээн авсан байна. Төлөвлөгөөний 3.1-т заагдсан ажлын хүрээнд: Авлигын эрсдэл ба алига гарах боломжийг бууруулах чиглэлээр аж ахуйн нэгж, иргэд, олон нийтэд Гаалийн байгууллагын шинэ бүтэц болох Гаалийн цахим төвийн талаар болон гаалийн зарим бүрдүүлэлтийн талаар Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга Э.Лхагвасүрэн, ГУАБ Ө.Пунсалдулам, ГУБ Д.Ганбат нар REELS Монголын гааль нэртэй нүүр хуудсаар дамжуулан цахимаар суртчилан ажилласан. Төлөвлөгөөний 3.3-т заагдсан ажлын хүрээнд: 2024 оны 02-р сарын 04 ний өдөр ГЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга Ч.Тамираа Бүрдүүлэлтийн цахим төвийн нийт албан хаагч нарт "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", "Авлигийн эсрэг хууль"-аас анхаарах асуудал, хориглох заалт өдгөөр, Зөрчилтэй тэмцэх газрын дарга Ж.Орденболд бүрдүүлэлтийн явцад гарч буй нийтлэг алдаа, дутагдал, төрийн албан хаагчийн хориглох зүйл болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар анхааруулга, мэдээлэл хийсэн. Бүрдүүлэлтийн цахим төвийн нийт 59 албан хаагч нар 2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд буюу 2024 оны 02-р сарын 15-ны өдрөөс өмнө гаргасан. Мөн тус төвийн албан хаагчаар томилогдсон өдрөөс 30 хоногийн дотор шинээр томилогдсон талаар ХАСХОМ-ыг гарган мэдүүлсэн болно. Төлөвлөгөөний 3.3.2-т заагдсан ажлын хүрээнд: -БЦТ нь нүүр тулсан харилцаанаас татгалзаж, цахимаар Гаалийн бүрдүүлэлт хийхээс гадна иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай гаалийн хууль тогтоомж, гаалийн үнэ үнэлгээтэй холбоотой гомдол саналд зөвлөгөө, мэдээ, мэдээллийг хүргэх зорилгоор 7000-1280 дугаарын суурин утсыг 7 хоног өдөр бүр 09.00-20.00 цаг хүртэл тасралтгүй, амралтгүй ажиллуулж байна. Тайлант хугацаанд тус төвийн гомдол, санал хүлээж авах 7000-1280 утсанд ирсэн дуудлаганаас 4785 дуудлагыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. -Авлигатай тэмцэх газраас ирсэн 2024 оны 04-р сарын 16-ны өдрийн албан тоотын дагуу Гаалийн бүрдүүлэлт хийж буй гадаад худалдаанд оролцогч нарын бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалт хийсэн гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдлын нягтлан шалгасан талаар иргэд, аж ахуй нэгжид тухайн шийдвэрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч байх, хууль тогтоомжийг сурталчлах талаар тодорхой ажлыг зохион байгуулан 2024 оны 05-р сарын 14-ний өдрийн 01-8/1913 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.		
Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх							
1.	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэхээр төвийн дарга-1, ББГУАБ-6, ББГУБ-51, ТУ-2 албан хаагчдын орон тоотой ажиллаж байна. Гаалийн бүрдүүлэлт хийсэн байдлыг импортоор нь авч үзэхэд 2024 оны эхний хагас жилд 6.09 тэрбум ам.долларын статистик үнийн дүнтэй бараанд 198.1 мянган бүрдүүлэлт хийж, 1.8 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, 2.97 их наяд төгрөгийн татварыг ногдуулж, гаалийн газар хороодын түр данс болон төрийн сангийн улсын төсвийн орлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна. Өдөр тутмын үйл ажиллагааг ГУАБ нар БТКУС кодоор хувиарлан авч хяналт тавин ажиллаж ба нийт ГУБ нарыг 6 багт хувааж 1 сараар ээлжлүүлэн БТКУС, гомдол маргаан болон мэдүүлгийн алдааг давхар хянаж ажиллаж байна. Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангуулах чиглэлээр БЦТ-ийн хийж хэрэгжүүлсэн ажлыг дараах байдлаар ангилан авч үзэх боломжтой байна. Үүнд: -Хилийн бүсийн гаалийн газар хороодын ажиллах цагийн хуваарь, хоёр улсын хилийн боомтуудын ажиллах хуваарийн дагуу хуваарьт гаалийн улсын байцаагч нар, гаалийн улсын ахлах байцаагч	2024.01.01-2024.06.10	

				хүлээн авсан байна. Төлөвлөгөөний 3.1-т заагдсан ажлын хүрээнд: Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр аж ахуйн нэгж, иргэд, олон нийтэд Гаалийн байгууллагын шинэ бүтэц болох Гаалийн цахим төвийн талаар болон гаалийн зарим бүрдүүлэлтийн талаар Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга Э.Лхагвасүрэн, ГУАБ Ө.Пунсалдулам, ГУБ Д.Ганбат нар REELS Монголын гааль нэртэй нүүр хуудсаар дамжуулан цахимаар суртчилан ажилласан. Төлөвлөгөөний 3.3-т заагдсан ажлын хүрээнд: 2024 оны 06-р сарын 04-ний өдөр ГЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга Ч.Тамираа Бүрдүүлэлтийн цахим төвийн нийт албан хаагч нарт "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", "Авлигийн эсрэг хууль"-аас анхаарах асуудал, хориглох заалт сэдвээр, Зөрчилтэй тэмцэх газрын дарга Ж.Эрдэнэболд бүрдүүлэлтийн явцад гарч буй нийтлэг алдаа, дутагдал, төрийн албан хаагчийн хориглох зүйл болон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар анхааруулга, мэдээлэл хийсэн. Бүрдүүлэлтийн цахим төвийн нийт 59 албан хаагч нар 2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд буюу 2024 оны 02-р сарын 15-ны өдрөөс өмнө гаргасан. Мөн тус төвийн албан хаагчаар томилогдсон өдрөөс 30 хоногийн дотор шинээр томилогдсон талаар ХАСХОМ-ыг гарган мэдүүлсэн болно. Төлөвлөгөөний 3.3.2-т заагдсан ажлын хүрээнд: -БЦТ нь нүүр тулсан харилцаанаас татгалзаж, цахимаар Гаалийн бүрдүүлэлт хийхээс гадна иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй, түргэн шуурхай гаалийн хууль тогтоомж, гаалийн үнэ үнэлгээтэй холбоотой гомдол саналд зөвлөгөө, мэдээ, мэдээллийг хүргэх зорилгоор 7000-1280 дугаарын суурин утсыг 7 хоног өдөр бүр 09.00-20.00 цаг хүртэл тасралтгүй, амралтгүй ажиллуулж байна. Тайлант хугацаанд тус төвийн гомдол, санал хүлээж авах 7000-1280 утсанд ирсэн дуудлаганаас 4785 дуудлагыг хүлээн авч шийдвэрлэсэн байна. -Авлигатай тэмцэх газраас ирсэн 2024 оны 04-р сарын 16-ны өдрийн албан тоотын дагуу Гаалийн бүрдүүлэлт хийж буй гадаад худалдаанд оролцогч нарын бүрдүүлэлтийн бичиг баримтын шалгалт хийсэн гаалийн улсын байцаагчийн шийдвэрт гаргасан гомдлын нягтлан шалгасан талаар иргэд, аж ахуй нэгжид тухайн шийдвэрийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч байх, хууль тогтоомжийг сурталчлах талаар тодорхой ажлыг зохион байгуулан 2024 оны 05-р сарын 14-ний өдрийн 01-8/1913 тоот албан бичгээр хариуг хүргүүлсэн.			
Зорилт 2: Улсын хилээр хууль бусаар бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхтэй тэмцэх							
1.	Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын шалгалт хийсэн байдал	Хэрэгж илт, гүйцэтг элээр	-	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд бүрэн алдаагүй хийж, зохих төлөвт	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангаж, бичиг баримтын шалгалтыг горимын шаардлага, хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэхээр төвийн дарга-1, ББГУАБ-6, ББГУБ-51, ТУ-2 албан хаагчдын орон тоотой ажиллаж байна. Гаалийн бүрдүүлэлт хийсэн байдлыг импортоор нь авч үзэхэд 2024 оны эхний хагас жилд 6.09 тэрбум ам.долларын статистик үнийн дүнтэй бараанд 198.1 мянган бүрдүүлэлт хийж, 1.8 тэрбум төгрөгийн хураамж төвлөрүүлж, 2.97 их наяд төгрөгийн татварыг ногдуулж, гаалийн газар хороодын түр данс болон төрийн сангийн улсын төсвийн орлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна. Өдөр тутмын үйл ажиллагааг ГУАБ нар БТКУС кодоор хувиарлан авч хяналт тавин ажиллаж ба нийт ГУБ нарыг 6 багт хувааж 1 сараар ээлжлүүлэн БТКУС, гомдол маргаан болон мэдүүлгийн алдааг давхар хянаж ажиллаж байна. Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны бичиг баримтын бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангуулах чиглэлээр БЦТ-ийн хийж хэрэгжүүлсэн ажлыг дараах байдлаар ангилан авч үзэх боломжтой байна. Үүнд: -Хилийн бүсийн гаалийн газар хороодын ажиллах цагийн хуваарь, хоёр улсын хилийн боомтуудын ажиллах хуваарийн дагуу хуваарьт гаалийн улсын байцаагч нар, гаалийн улсын ахлах байцаагч	2024.0 1.01- 2024.0 6.10	

			бүрэн байршуулсан байна. 2. Судалгаа, дүн шинжилгээг хийж, санал дүгнэлтийг удирдлага болон холбогдох нэгжүүдэд хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан байна. 3. Гаалийн газар, хороодын удирдлагуудтай харилцан мэдээлэл, солилцож, хамтран ажилласан байна.	нарын өдрийн 09:00-18:00 цагаар, 11.00-20:00 цагаар ажиллуулахаар тухай бүрт хуваарь гаргах, бямба, ням гарагуудад мөн ажлын ачааллыг харгалзан нийт гаалийн улсын байцаагч, гаалийн улсын ахлах байцаагч нарын 20-25 хүртэлх хувийг дээрх цагийн хуваарийн дагуу ажиллуулж байна. Үүн дээр бүх нийтийн амралтын өдрүүдэд ажиллах хилийн боомтуудын гаалийн бүрдүүлэлтийг хэвийн үйл ажиллагааг хангуулах зорилгоор хуваарь гарган, тус хуваарийн дагуу үйл ажиллагааг тасралтгүй, шуурхай зохион байгуулан ажиллаж байна. - Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааг бууруулах, гаалийн мэдүүлгийн алдааг бууруулах зорилгоор 8703-т хамаарах суудлын автомашин, 8704-т хамаарах ачааны автомашин, 8427-8429-т хамаарах техник, хүнд машин механизмын гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын хяналт шалгалтыг дагнан хийх ажлыг туршиж эхлэсэн ба үүний үр дүнд гаалийн бүрдүүлэлтэд зарцуулж байгаа цаг хугацаа буурч, үнэ үнэлгээний нэгдмэл байдал илүү сайн хангагдаж эхлээд байна. - Ажлын байрны хэвийн нөхцөл, интернэт сүлжээ, компьютер, техник хэрэгсэл, сандал, ширээний хүртээмжийг сайжруулах чиглэлээр тухай бүрт холбогдох газруудад саналыг хүргүүлэн шийдвэрлүүлж ажилласан. Үүнээс дурдвал ажлын байрны засвар, тохижилтын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр ажлын хэсэг гарган, шаардлагатай техник хэрэгсэл, тавилгын жагсаалт, ажлын байрны ерөнхий зураг төсөл зэргийг хийж гүйцэтгүүлсэн байна. Мөн гаалийн улсын байцаагч нарыг бичиг баримтын шалгалт хийхэд шаардлагатай давхар дэлгэцүүдийг шинээр байрлуулж, шинээр томилогдсон алба хаагч нарт иж бүрэн компьютерээр ханган ажилласан. - Гаалийн бүрдүүлэлтийн явцад гарч буй гаалийн үнэ үнэлгээ, барааны ангиллын гомдол, хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор БТКУС үнэ, үнэлгээний хэсэгт 1800-1281 утаснаас шууд холбогдох боломжтой суурин утсыг холбож, ашиглалтад оруулан, байнгын хүн томилон, дуудлага хөтлөлт хийж, шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. - Гаалийн бүрдүүлэлтийг гаалийн байгууллагад мэдүүлэх шатнаас эхлэн алдаагүй, үнэн зөв байлгах зорилгоор 2024 оны 5-р сард ГУАБ Ө.Пунсалдулам УБГТ-тай гэрээтэй гаалийн зуучлагч байгууллагын гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд "Гаалийн бүрдүүлэлтэд анхаарах зүйлс" сэдвээр, 2024 оны 6-р сард ГУАБ Д.Бурмаа давтан сургалтад хамрагдаж буй гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд "Бүрдүүлэлтийн цахим төв"-ийн үйл ажиллагааны тухай болон "Гаалийн мэдүүлгийн нийтлэг алдаа, түүнийг бууруулах нь" сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан ба цахимаар "Бараа нийлүүлэх нөхцөл" сэдэвт лекцийг зочин багш Норжинсүрэнгээр танилцуулж ажилласан. - Гаалийн бүрдүүлэлтийг бүрдүүлэлтэд анхаарах шаардлагатай анхааруулга, санамж, зарим бүрдүүлэлт, бараанд хийсэн судалгаа дүн шинжилгээг тогтмол хийж ажилласан бөгөөд тайлант хугацаанд бүртгэл хийгдсэнээр 31 удаагийн санамж, анхааруулгыг viber цахим группт Горимын шаардлага хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хүрээнд гаалийн бүрдүүлэлтийг хийх чиглэлээр: -Гаалийн бүрдүүлэлтийн нийт горимын хэрэгжилтийг хангасан байдлыг авч үзэхэд тайлант хугацаанд 132 удаа горимын шаардлага хангаагүй мэдүүлгийг засварт буцааж, өөр горимд байршуулж ажилласан байна. - Улсын хилээр түр хугацаагаар орох, гарах горимын хэрэгжилт ихсэж байгаатай холбогдуулан түр горимоор улсын хилээр орох бараа, тээврийн хэрэгслийн гаалийн үнэлгээг анхаарч ажиллах, бүрмөсөн импорттой адилтган гаалийн үнийг тодорхойлж ажиллах, горимын шаардлагын дагуу тэмдэг, тэмдэглэгээ хийгдсэн, гаалийн хяналт тавих боломжтой, хэрэглээний явцад элэгдэж, алга болохгүй бараанд тухайн түр горимыг хэрэгжүүлж ажилласны үр дүнд 500 горимоор мэдүүлсэн 6 мэдүүлгийн барааг горимын шаардлага хангахгүй тул 400 горимд байршуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. - Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд МУ-ын хууль, засгийн газрын тогтоолын дагуу гаалийн болон бусад татвараас хэсэгчлэн болон бүрэн чөлөөлөгдөж	
--	--	--	---	--	--

				бүрмөсөн болон түр хугацаагаар орох горимын хяналтыг сайжруулах зорилгоор ГЕГ-ын дэд дарга, Татвар орлогын газраас ирүүлсэн чиглэлийг сайтар баримталсны үр дүнд 403 горимоор гаалийн болон бусад татвараас чөлөөлж дотоодын хэрэглээнд бүрмөсөн оруулахаар мэдүүлсэн 21 мэдүүлгийн барааг 400 горимд шилжүүлэн гаалийн болон бусад татварыг ногдуулж, барагдуулан, 2 зөрчлийн шинжтэй үйлдэлд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу арга хэмжээ авч ажиллалаа. МУЗГ-ын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 180 дугаар тогтоолын хэрэгжилт, 2021 оны 143 дугаар тогтоолуудын хүрээнд импортлогдож байгаа мал, амьтны тэжээл, тэжээлийн овъёос, бордооны импортод тавих бичиг баримтын хяналтыг сайжруулах зорилгоор бичиг баримтын хяналтыг сайжруулах, гаалийн төв лабораторид хамруулж /хивэг, гурилнаас бусдыг/ бичиг баримтын шалгалтыг дуусгавар болгон ажиллаж байна. -Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлд төвийн ГУАБ Д.Бурмаа "Эм, эмнэлгийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтэд анхаарах зүйлс", ЦЕГ-ын лицензийн төвөөс "Галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийг таних, импортлох зарим асуудлууд" сэдвээр гаалийн улсын байцаагч нарт сургалт зохион байгуулсан бөгөөд сургалт эдгээр сургалтуудын мөрөөр 9018-д хамаарах гаалийн "0" тарифтай бараанд тавих хяналт сайжирч, тус ангилалд хамаарахгүй барааны гаалийн бүрдүүлэлтүүдийг засварлаж, галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн гаалийн бүрдүүлэлтэд тавих бичиг баримтын шалгалтыг нэмэгдүүлэх заавруудыг өдөр тутам өгч ажиллаж байна. - Мөн 7 хоног бүрийн Мягмар гаригт гарч буй алдаа болон шинээр хэрэгжсэн хууль тогтоомж, УИХ, ЗГ-ын тогтоол, тушаал шийдвэрийн талаар танилцуулж, тухайлсан 1 барааг сонгож мэргэжлийн хүнийг урьж ирүүлэн сургалт зохион байгуулж, ГУБ нарын мэдлэгийг чадавхижуулах арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллаж байна. Мэдүүлгийн төлөв: Бүрдүүлэлтийн цахим төвд импортын гаалийн мэдүүлгийг төвлөрсөн байдлаар хянадаг болсноор гаалийн холбогдолтой хууль, гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон бараа, тээврийн хэрэгслийг Монгол улсын нутаг дэвсгэрт оруулах буюу импортлохтой холбогдсон бусад хууль, журмууд нэгдсэн байдлаар хэрэгжиж, бичиг баримтын хяналт ижил байдлаар хийгдэх нөхцөл бүрэлдэж эхлээд байна. Уг ажлын хүрээнд илрүүлсэн алдааг засварлаж, зохих төлөвт байршуулсан. Үүнд: -ТОГ 2024/12 тоот дотоод зурвасын дагуу МУЗГ-ын 107 дугаар тогтоолд хамрагдахгүй барааны нийт 19 гаалийн мэдүүлгийг засварласан. Мөн БЦТ-д хүсэлт гаргасан ААН-н хүсэлтийг нягтлан 107-р тогтоолд хамрагдах 6 мэдүүлэгийг засварлан зохих төлөвт оруулсан. Дотоод зурвас 2024.03.20 №35 /ТОГ, СДШГ/ - Хуулийн хэлтэст [REDACTED] ХХК-ийн 2024.02.22-ны өдрийн УБГ-ын АБТЭМА ГХБ-ээр 400 горимоор [REDACTED] дугаартай мэдүүлгээр мэдүүлсэн 638 ширхэг "матрац" гэх бараатай холбоотой гомдлын дагуу барааны нэр төрөл, ангиллын кодыг тодорхойлохоор ГУБ томилсон ба уг бараа нь агаараар хийлэгддэггүй, порлонон дүүргэгчтэй, нимгэн синтетикен гадартай, матрацан дээр тавьдаг гудас /topper/ байсан ба БТКУС-ийн 9404.90.00 кодоод хамаарсан. Дотоод зурвас 2024.04.02 №48 - СДШХ 2023 оны импорт болон экспортын гаалийн мэдүүлгүүдийг засах шаардлагатай 22 мэдүүлгийн жагсаалтыг хүргүүлж засварлаж дууссан. /Дотоод зурвас 2024.04.09 №50/ - Манай төвөөс гаалийн мэдүүлгийг зохих төлөвт байршуулах ажлыг сар бүр тогтмол хянаж, төлөвийн үлдэгдэлгүй ажиллахаар зорьж байгаа бөгөөд бичиг баримтын шалгалт хариуцсан гаалийн улсын байцаагчаас шалтгаалаагүй үлдэгдэл буюу гаальд мэдүүлсэн-11, ббгуб руу буцаасан-0, ГЕГ-т хүсэлт илгээсэн-0, ГЕГ-аас засварт буцаасан-0, засварт буцаасан-41 мэдүүлэг байна. 2. БЦТ-өөс гаалийн бүрдүүлэлт, бараатай холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийж, санал дүгнэлтийг удирдлага болон холбогдох нэгжүүдэд хүргүүлж, мэдээллээр хангаж ажиллах чиглэлээр ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагад 91 дотоод зурвас илгээж, 70 дотоод зурвас хүлээж	
--	--	--	--	---	--

			авснаас хариутай 43 зурваст хариуг хүргүүлэн ажилласан байна. Эдгээрээс тодорхой байдлаар дурдвал: -Зөрчилтэй тэмцэх газарт зөрчлийн хэрэгт хамаарах 10 нэр төрлийн барааны ангиллын код болон гаалийн үнийг гаргаж хүргүүлсэн. /Дотоод зурвас 2024.02.07 №7/ - БАҮХ-т ГТГТХ 15.2.2.4-д заасны дагуу БТКУС-ийн зүйл 8703-д хамаарах АНУ-аас импортлож байгаа суудлын автомашины үнийн судалгааг хийж, "Импортын барааны гаалийн үнийг шалгах, импортын барааны гаалийн үнийг тодорхойлох заавар"-ын 8.1-д заасны дагуу хянуулахаар хүргүүлсэн. /Дотоод зурвас 2024.02.19 №14/ - БАҮХ Гаалийн газар, хорооны бүрдүүлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, интернетээр олон нийтэд тараасан үнэ зэргийг харьцуулан судалгаа хийж хүргүүлсэн. /Дотоод зурвас 2024.03.01.№24/ 2023 онд импортолсон 50 нэр төрлийн барилгын материалын гаалийн үнийн судалгааг газар хороодоор гаргаж, дундаж үнэ, импортын тоо хэмжээг нэгтгэн, холбогдох хэлтэст хүргүүлсэн./ - БАҮХ-т ГТГТХ 15.2.2.4-д заасны дагуу БНХАУ-с импортлож байгаа чирэгч автомашин, чиргүүлийн үнийн судалгааг хийж, хянуулахаар хүргүүлсэн. /Дотоод зурвас 2024.03.05 №26/ - Сais системийн татварын хувь хэмжээ -үнийн мэдээллийн сан-мэдүүлгийн бичлэг-эвдрэлтэй-тийм гэсэн сонголт ажиллахгүй байсныг ГЕГ-ын Мэдээлэл технологийн хэлтэстэй холбогдож засуулсан. - Автомашины км-ийн заалтыг засах тохиолдол их гарч байгаа тул ХШГУБ бодит байдалд шалган барааны онцлог шинж, КМ-ийн гүйлтийг фото зургаар баталгаажуулан, үзлэг хийсэн тэмдэглэл хавсарган мэдүүлэгт засвар оруулж болох эсэх талаар чиглэл авсан. /Дотоод зурвас 2024.01.30 №4/ - Тариф татварын газарт Зөрчилд холбогдсон барааны гарал үүслийг нотлох бичиг баримтыг дахин гаргаж өгвөл нэн тааламжтай тарифаар тооцож болох эсэх талаар чиглэл авсан. /Дотоод зурвас 2024.02.15 №1/ - БДШ газарт 2 удаагийн дотоод зурвасаар 7 ААН-ийн мэдээлэл хүргүүлсэн. - ОНХТ-тэй хамтран БЦТ-ийн талаар танилцуулга, Гаалийн бүрдүүлэлт үйл явц, Гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай бичиг баримтууд гэсэн 3 сэдвээр видео контент бэлтгэж, олон нийтийн сүлжээнд байршуулсан. - ОНХТ-д хүсэлт гаргаж Монголын гааль фэйсбүүк хуудсанд БЦТ-д гомдол гаргах мэдээллийг нийтлүүлж, олон нийтэд мэдээлэх ажлыг хийж гүйцэтгэсэн. - МТГ-т БЦТ-ын эрх бүхий албан тушаалтнуудын бичиг баримтын шалгалт хийх явцад Гаалийн хууль тогтоомж зөрчсөн үйлдлүүдийг илрүүлэн Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу арга хэмжээ авч гадаад худалдаанд оролцогч нарт түргэн шуурхай шийтгэл ногдуулах шаардлагын үүднээс КАИС програмд зөрчил нэмэх үйлдлийг хийхэд "Терминал" сонгох хэсэгт "ГЕГ-БЦТ" гэсэн сонголтыг нэмж оруулах санал хүргүүлсэн. /Дотоод зурвас 2024.03.21 №39/ - Бүрдүүлэлтийн цахим төвийн чиг үүргийн хүрээнд ААН-үүдэд судалгаа хийж, хууль сахилт сайн 19 ААН-ын эрсдэл тооцож болох мэдээллийг "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийн дагуу 4 удаа гаргаж 2024.02.01-ний өдрийн №5, 2024.04.12-ны өдрийн №52, 2024.05.06-ны өдрийн №58, 2024.05.30-ны өдрийн №72 тоот дотоод зурвасуудаар тус тус ЭУХ-т хүргүүлсэн. - МТГ-т мэдүүлгийн алдааг бууруулах, гаалийн бүрдүүлэлтийн бичиг баримтын хяналт, шалгалтад зарцуулж байгаа цаг хугацааг бууруулах зорилгоор КАИС, СЕПС системд оруулах шаардлагатай байгаа саналуудыг жагсаан 2024.05.09-ний өдрийн 62 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. 3. ЗҮГГ-ын холбоо баригчаар дамжуулж тайлант хугацаанд 9 удаагийн лавлагаа авч, үнийн дүн зөрүүтэй мэдүүлсэн 5 мэдүүлгийн үнийг дахин хянаж, 137.5 сая төгрөгний татвар нөхөн төлүүлсэн / 03-2141016-24-130002. 03-2141016-24-130010. 03-2211022-23-131626. 03-2211022-24-130028. 03-2151009-24-130607. 03-2131003-24-131457/. - Мөн Митайм монголиа ХХК /ГХО/-ны 4 мэдүүлгээр /6 автомашин/ мэдүүлсэн бараанд (34560,32 ам.доллараар мэдүүлэн 18,113,115.3 төгрөгийн гаалийн болон бусад татвар төлөхөөр мэдүүлсэн байсанд) эрсдэл тооцон ЗҮГГ-ын даргад мэдэгдэн, холбоо баригчаар дамжуулан хамтарсан	
--	--	--	---	--

				манифестын лавлагаа авч 202,488,669.3 төгрөгийн гаалийн болон бусад татварыг төлүүлсэн. /Зөрүү нь 184,375,553.8 төгрөг/ - Гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг шалгах явцад зарим барааны мэдээлэл дутуу, буруу оруулсанаас хамаарч бүрдүүлэлтийн явцад хүндрэлтэй байсан тул БНХАУ-д үйлдвэрлэгдсэн суудлын автомашины vin17.com сайтаар арлын дугаараар хайлт хийхэд техникийн үзүүлэлт лавлах санд бүрэн оруулах, мөн 87.05, 84, 85, болон 90 дүгээр бүлэгт хамаарах барааны бичиглэлийн талаар 01-8/2037 тоот албан бичгээр ГБМ нарт чиглэл хүргүүлсэн. - Улсын төсвийн орлого бүрдүүлэх чиглэлээр ТОГ, татварын орлогын төлөвлөгөө биелүүлэх ажлын хэсэгтэй хамтран 2 удаа, гаалийн бүрдүүлэлт дэх бичиг баримтын шалгалтын явцад үүсч байгаа нөхцөл байдлыг танилцуулах, санал солилцох чиглэлээр 1 удаа нийт 3 удаа гаалийн газар хороодын даргатай онлайн уулзалтыг зохион байгуулж, гаалийн газар хороодоос ирсэн санал, дүгнэлтүүдийг өдөр тутмын үйл ажиллагаанд анхаарах талаар гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарт чиглэл өгөн ажиллаж байна. - БӨГ-аас 2024.04.11-ний өдрийн 01/171 тоот албан бичгээр ирүүлсэн Нефть бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн танилцуулгын хариуг 2024.05.12-ны дотоод сүлжээгээр өгч, утсаар тайлбар өгч ажилласан.		
2.	Гаалийн бүрдүүлэлтэд гарсан алдаа болон зөрчил илрүүлэлт, шийдвэрлэлт, алдааг бууруулах чиглэлээр зохион байгуулсан ажил	Илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татварын дүн, торгуулийн дүн	-	1. Мэдүүлэгчийн гаргасан алдааг илрүүлсэн тоо, нийт бүрдүүлэлтэд эзлэх хувийг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар нэмэгдүүлнэ. 2. Бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийн тоо, нөхөн төлүүлсэн татвар, торгуулийн дүнг өмнөх оны мөн үеэс 2 хүртэл хувиар нэмэгдүүлнэ. 3. Барааны ангиллын луйврыг илрүүлэх, урьдчилан 1. Бүрдүүлэлтийн цахим төв нь 2024 оны эхний хагас жилийн байдлаар Гаалийн ерөнхий газрын харьяа газар, хорооны хэмжээнд 199806 импортын, 367975 экспортын, нийт 567781 гаалийн мэдүүлгийн 1404210 бичлэгээр гаалийн бүрдүүлэлт хийсэн байна. Тайлант хугацаанд нийт 989 гаалийн зуучлагч аж ахуйн нэгж, байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн болон зуучлагчид 41989 засварт буцаалт хийсэн байна. Гаалийн зуучлагч байгууллагын мэдүүлгийн засварт буцаалтыг авч үзвэл нийт 41989 удаагийн засварт буцаалт байгаагаас дагалдах баримт нэмсэн 4638 засварт буцаалтыг хассанаар 37351 бичлэг засварласан байна. 2023 оны эхний хагас жилд 426966 гаалийн мэдүүлгээр 1171709 бичлэгийг хянаж, 33400 бичлэг засварт буцаасан нь нийт бичлэгийн 2,9% эзэлж байсан бол 2024 оны эхний хагас жилд 567781 гаалийн мэдүүлгээр 1404210 бичлэгийг хянаж 41989 бичлэгийг засварт буцаасан нь нийт бичлэгийн 3% эзэлж байгааг харьцуулбал мэдүүлгийн тоо 140815, бичлэгийн тоо 232501, засварт буцаалт 0,1% өсөлттэй харагдаж байна. Бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад гаалийн хууль тогтоомжид заасан эрхээ хэтрүүлсэн 9 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний гаргасан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу тус бүр 300000 төгрөгөөр торгосон. Гаалийн бүрдүүлэлтийн явцад гарч буй алдааг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар: Бичиг баримтын бүрдүүлэлтийн явцад гарч буй алдаанд дүн шинжилгээ хийж, тухайн төрлийн алдааг бууруулах, цаашид давтан гаргуулахгүй байх чиглэлээр дараах сэдвээр гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. Үүнд: ➢ Экспорт, импортын болон улс хооронд дамжин өнгөрүүлэх бараанд хийх гаалийн бүрдүүлэлт; ➢ Гаалийн горим, горимын ангилал, төрөл, горимын нөхцөл шаардлага; ➢ Барааг гаалийн зорилгоор таних, тодорхойлох, кодлох; ➢ Экспорт, импортын барааны гаалийн үнэ, түүнийг тодорхойлох үндсэн арга; ➢ Гаалийн үнэ ба Инкотермс; Барааны гарал үүслийг тодорхойлох; ➢ Гаалийн татвар, гаалийн тариф, тарифын бус зохицуулалт; ➢ Экспорт, импортын барааг дагалдах гадаад худалдааны бичиг баримт, гаалийн бүрдүүлэлтэд түүний ач холбогдол; ➢ Гадаад худалдааны гэрээ, түүний нөхцөл, барааг гаалийн байгууллагад мэдүүлэхэд шаардагдах мэдээлэл; Мэдүүлэгчийн эрх, үүрэг, хариуцлага;	2024.01.01-2024.06.10	

			сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна. 4. Гааль зөвшөөрөв төлөвөөс засварт буцааж мэдүүлэгт засвар оруулсан байдлыг өмнөх оны мөн үеэс 1 хүртэл хувиар бууруулна.	➤ Гаалийн мэдүүлэг нөхөн бичих, CEPS системд ажиллах. 2. Гаалийн бүрдүүлэлтэд бичиг баримтын шалгалт хийх явцдаа Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль зөрчсөн нийт 55 зөрчлийг илрүүлэн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан Зөрчлийн тухай хуулийн 6 зүйлчлэлээр 66.15 сая төгрөгөөр торгож 19.6 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэн 85.74 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. 2023 оны эхний хагас жилд нийт 46 зөрчлийг илрүүлэн Зөрчлийн тухай хуулийн 7 зүйлчлэлээр 46 зөрчилд 43.83 сая төгрөгийн торгуулийг ногдуулан 7.65 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн. Энэ нь 2024 оны үзүүлэлттэй харьцуулахад зөрчлийн тоо 9 буюу 19.57 хувь, торгуулийн дүн 22.32 сая төгрөг буюу 50.93 хувь, нөхөн төлсөн татварын дүн 11.94 сая төгрөг буюу 156.11 хувиар тус тус нэмэгдсэн байна. Зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар: Бүрдүүлэлтийн цахим төвийн гаалийн улсын байцаагч нарын бичиг баримтын шалгалтын явцад илрүүлсэн зөрчлийг хуулийн дагуу шалган шийдвэрлэх, зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: ➤ Гаалийн ерөнхий газрын Зөрчилтэй тэмцэх газар, Хүний нөөцийн хэлтэст хүсэлт гарган зөрчилтэй тэмцэх, чиглэлийн гаалийн улсын байцаагчийн томилуулсан; ➤ Дотооддоо сар бүр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах албан хаагч нарын судалгааг гарган дотооддоо хуваарь гаргаж ажиллаж байна. /Энэ үзүүлэлт нь ажлын ачааллын хувьд болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд алдаа дутагдал гаргахгүй байх давуу талтай; ➤ Бичиг баримтын шалгалтын явцад аль хол хилийн боомтуудад гарч буй зөрчлийг бичиг баримтын шалгалт хийсэн тэмдэглэл үйлдэн зөрчил хариуцсан ГУАБ-д мэдэгдэн бүртгэлжүүлж Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 харьяаллын дагуу шилжүүлэн үр дүнд хяналт тавьдаг болсон; ➤ Гарч буй зөрчлийн талаар дотооддоо гаалийн улсын байцаагч нарт сэрэмжлүүлэн анхааруулга өгдөг; 3. Гаалийн улсын байцаагч нарыг мэргэшүүлэх чиглэлээр 97 бүлгийн барааг хуваарилан Бүрдүүлэлтийн цахим төвийн даргаар батлуулан хариуцсан бүлгийн барааны гаалийн бүрдүүлэлтэд холбогдох хууль тогтоомж, гаалийн бүрдүүлэлтийн судалгааг хийлгэж тусдаа хавтас үүсгэн санг бүрдүүлж байна. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж, ангиллын луйврыг илрүүлж ажилласан байна. Бүрдүүлэлтийн явцад барааны ангиллын код хянаж 831 бичлэгт өөрчлөлт оруулсан. Үүнээс: - [REDACTED] мэдүүлэг бүхий [REDACTED] ХХК-ний 1901.90.00 код бүхий СҮҮН КРЕМ хэмээн мэдүүлсэн барааны ангиллын кодыг хянаж 0406.30.00 код бүхий Бяслаг байсныг илрүүлсэн. 0406.30.00 барааны гаалийн татварын тариф 15 хувь, бөгөөд нөхөн төлүүлсэн татвар 46 сая төгрөгийг нэмж төлүүлж ААН байгууллагыг 3 сая төгрөгөөр торгосон. - Тарифын бус хязгаарлалттай барааны хяналт [REDACTED] мэдүүлгээр [REDACTED] ХХК-ний 3912.31.00 БТКУС код бүхий Натрийн карбоксиметилцеллюлоз бараанд Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу 0093259 дугаартай шийтгэлийн хуудсаар [REDACTED] ХХК-ийг 3 сая төгрөгөөр торгов. - [REDACTED] дугаар бүхий Дийлэгчтэнгэр ХХК 3808.93.00 код бүхий Гербицид зэрэг шавьж устгагч зэрэг барааны лицензнээс илүү бараа мэдүүлснийг Тухайн мэдүүлгээс Диастар, ВР - 20 л, Азорит, СК - 20 л тус тус импортлох лицензгүй нэвтрүүлсэн зөрчлийг 2024 оны 06-р сарын 12-ны өдөр 15 цаг 32 минутад бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн бичиг баримтын байцаагчаас засварт буцааснаар илрүүлэн ЗХБ-ийн дугаар 157, шийтгэлийн хуудас №0090671, ЗТХ 11.21 зүйлсийн 11 дэх хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийг 1 сая төгрөгөөр торгож тухайн 40 л бараа бүтээгдэхүүнийг хураан авч шийдвэрлэв. Бусад бараа бичиг баримтын зөрчилгүй, биет үзлэгээр зөрчилгүй. Тусгай	
--	--	--	---	--	--

				зөвшөөрлийн эх хувиас хасалт хийсэн. Барааны ангилал, үнэлгээний луйвраас урьдчилан сэргийлэх чиглэлээр: Автомашинны болон хил орчмын үнийн судалгааг хийж, ГЕГ-ын холбогдох нэгжээр хянуулан баталгаажуулж, гаалийн үнийг тодорхойлоход ашигласан байна. -БТКУС-ийн зүйл 87.03-д хамаарах АНУ-аас импортолж байгаа суудлын автомашинны үнийн судалгааг CAIS-ийн 2023 оны бүрдүүлэлтийн мэдээ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэтэй харьцуулан хянаж, 62 барааны үнийг CAIS-ийн автомашинны үнийн судалгааг хийж 1202401000002 дугаартай хавтсанд, - БТКУС-ийн Зүйл 87.04, 87.16-д хамаарах БНХАУ-аас импортлож байгаа чирэгч автомашин, чиргүүлийн үнийн судалгааг CAIS-ийн бүрдүүлэлтийн мэдээ, 2023 оны судалгааны үнэ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэ зэрэгтэй харьцуулан нийт 5 маркын 2014 оноос 2023 оны хооронд үйлдвэрлэгдсэн 154 нэр төрлийн чирэгч автомашин, 7 төрлийн 2014 оноос 2023 оны хооронд үйлдвэрлэгдсэн 63 ширхэг чиргүүлийн үнийн судалгаа хийж 01202401000003 дугаартай хавтсанд, - БТКУС-ийн зүйл 8606-д хамаарах ОХУ-аас импортолж байгаа зарим ачааны вагоны үнийн судалгааг CAIS-ийн 2023 оны бүрдүүлэлтийн мэдээ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэ зэрэгтэй харьцуулан 28ш ачааны вагоны үнийн судалгааг хийж 01202402000001 хавтсанд байршуулан, ГЕГ-ын БАҮХ-р хянуулан баталгаажуулсан. - Гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг шалгах явцад зарим барааны мэдээлэл дутуу, буруу оруулснаас хамаарч бүрдүүлэлтийн явцад хүндрэлтэй байсан тул БНХАУ-д үйлдвэрлэгдсэн суудлын автомашинны vin17.com сайтаар арлын дугаараар хайлт хийхэд техникийн үзүүлэлт лавлах санд бүрэн оруулах, мөн 87.05, 84, 85, болон 90 дүгээр бүлэгт хамаарах барааны бичиглэлийн талаар 01-8/2037 тоот албан бичгээр ГБМ нарт чиглэл хүргүүлсэн. - 2024 оны эхний хагас жилийн байдлаар Автомашинны үнийн судалгаанд үндэслэн 16.8 тэрбум төгрөг, татвар нэмж төлүүлсэн байна. Мөн ГЕГ-ын БАҮХ-ээс өгсөн чиглэлийн дагуу БТКУС-ийн 8606-д хамаарах вагоны судалгааг хийж, CAIS системд 01202402000001 дугаартай байршуулж үнийн хяналтын зорилгоор ашиглаж байна. - ГЕГ-ын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2024.05.12-17-ны өдрүүдэд БАҮХ, ЗҮГТ-ын Гаалийн бүрдүүлэлтийн албаны албан хаагч нар болон МҮХАҮТ-ийн төлөөллийн хамт БНХАУ-ын Эрзэн, Бугат хотын барилгын материал, төмөр, төмөр хийц, хүнд машин механизм, тоног төхөөрөмж, ачааны автомашинны үнийн судалгаа хийхэд оролцсон. Ажлын хэсэг 206 нэр төрлийн барааны үнийн судалгааг нэгтгэхэд оролцон 0320240300002 дугаартай хавтсанд байршуулан үнийн судалгааг 2024.06.04-ний өдрөөс эхлэн үнэлгээний зорилгоор ашиглаж байна. - 2024 оны хилийн үнийн судалгаанд үндэслэн эхний хагас жилд 23.6 тэрбум төгрөг, татвар нэмж төлүүлсэн байна. - Судалгаа, дүн шинжилгээнүүдийг гаалийн бүрдүүлэлтийн, орлогын, горимын, хөнгөлөлт чөлөөлөлтийн гэх мэт олон чиглэлээр хийж, удирдлагыг мэдээллээр ханган, бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагааг сайжруулсан байна. - Тайлант хугацаанд 178 удаа орлогын мэдээг татварын төрөл, гаалийн газар хороо, бүрдүүлэлтийн тоо, үнэлгээний арга /мэдүүлэг, бичлэг, иргэн, ААН/ -г гарган дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. Мөн татварын орлогын дүн шинжилгээг 2.3, 5 сард гаргасан. Бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУБ нарыг чадавхижуулах чиглэлээр: Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хаагч нарыг мэргэшүүлэх, алдаа дутагдал гаргахгүй хуулийг нэг мөр хэрэгжүүлэх зорилгоор мэдээллийн цагийг долоо хоног бүрийн Мягмар гаригт өглөө 7:30 минутад хийж хэвшсэн. 1. ГЕГ-ын даргын 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн А/30 "Заавар батлах тухай" тушаал гаалийн бүрдүүлэлтэд гарч буй нийтлэг алдааны талаар нийт ГУБ, ГУАБ нарт		
--	--	--	--	---	--	--

				Бүрдүүлэлтийн цахим төвийн ГУАБ Ш.Наранцэцэг, ГУАБ Д.Бурмаа нар сургалт зохион байгуулсан - Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3 дахь хэсэг, мөн хуулийн 10 дугаар зүйл, бараа нийлүүлэх нөхцлийг гаалийн бүрдүүлэлтэд хэрхэн ашиглах талаар гаалийн итгэмжлэгдсэн зөвлөх С.Норжинсүрэнг урьж хичээл заалгасан. Сургалтанд нийт ГУБ, ГУАБ нар бүрэн хамрагдсан. - Галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн талаар ЦЕГ-ын галт зэвсгийн сургагч багш цагдаагийн ахмад Т.Дашцэрэвийг урьж сургалт хийсэн нийт ГУБ, ГУАБ нар хамрагдсан. - БТКУС-ын 70-р бүлэг "Шил ба шилэн эдлэл" - ГУАБ Пунсалдулам, ГУБ Ганбат нарын суудлын машиныг үйлдвэрлэсэн он сарыг хэрхэн шалгах, гаалийн нэгж үнийг хэрхэн тогтоох - ГУАБ Бурмаа БТКУС-ын 90.18, 90.19, 90.21, 90.22 зүйлд хамрагдах барааг зөв тодорхойлох - Замын хөдөлгөөний аюулгүй байдал, чирэгч, чиргүүлийн стандарт - Японы гаалийн туршлагаас - БАҮХ-ээс чирэгч, чиргүүл, уул уурхайн тоног төхөөрөмж, барилгын материал ангиллаар гаалийн үнэлгээн дээр хийсэн дүн шинжилгээ - БЦТ-ийн үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдөр гаалийн зуучлагч аж ахуйн нэгж, байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн болон зуучлагч нарт Гаалийн Бүрдүүлэлтийн Цахим Төвөөс "Гаалийн бүрдүүлэлтэд анхаарах асуудлууд" сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 100 гаруй аж ахуй нэгжийн 200 гаруй Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нар хамрагдсан. Тус сургалтыг гаалийн итгэмжлэгдсэн зөвлөх С.Норжинсүрэнг урьж ГУАБ Д.Бурмаа зохион байгуулсан. 4. 2024 оны эхний хагас жилийн байдлаар импортын 198143, экспортын 2817, нийт 200960 гаалийн мэдүүлгээр бичиг баримтын шалгалт хийсэн байна. Тайлант хугацаанд нийт 2206 мэдүүлгийг "гааль зөвшөөрөв" төлөвөөс засварласан байна. Үүнээс 752 мэдүүлгийг тухайн өдөрт нь, 232 мэдүүлгийг ГЕГ-аас шалгуулахаар буцаасан, 1222 мэдүүлгийг гаалийн газар, хороод ГЕГ-ын Статистикийн хэлтэст хүсэлт илгээн засварласан байна. Гаалийн мэдүүлэг бүрэн баталгаажсаны дараа "Гааль зөвшөөрөв" төлөвөөс буцааж засварласан мэдүүлгийн талаар: 2024 оны эхний хагас жилийн байдлаар "гааль зөвшөөрөв" төлөвөөс зассан нийт 2206 мэдүүлгийн гаалийн газар тухайн өдөрт нь засварласан 752 мэдүүлгээс бусад нийт 1454 гаалийн мэдүүлэг байгаагаас "татгалзсан" 11 мэдүүлэг, "хүчингүй" 0 мэдүүлэг, ГУБ-ын буруугүй үйл ажиллагаанаас хамааран буцаасан 67 мэдүүлэг /програмын шинэчлэлттэй холбоотой алдаа гарсан, аж ахуйн нэгж хүсэлт гаргасан, автомашины зураг засаж оруулах, үнэлгээний арга засах болон үнэлгээг шинэчлэн тогтоох, гаалийн төв лабораторийн дүгнэлт оруулах болон экспертизийн акт оруулах, зөрчлийн улмаас буцаагдсан, урьдчилсан бүрдүүлэлт, хуульд заасны дагуу тарифын өөрчлөлт оруулсан, хуулийн хугацаанд гарал үүслийн баримт гаргаж өгсөн гэх мэт/-ийг хасаад, мэдүүлэг бүрэн баталгаажсаны дараа гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн рүү буцааж засвар өөрчлөлт орсон 1371 мэдүүлэг байна. 2023 оны эхний хагас жилд нийт 1182 гаалийн мэдүүлэгт "гааль зөвшөөрөв" төлөвөөс засвар өөрчлөлт оруулсан бол 2024 онд 1371 мэдүүлгийг буцаан зассан нь өмнөх оны мөн үеэс 189 мэдүүлэг буюу 15.99%-иар өссөн үзүүлэлттэй байна. 2023, 2024 онуудын эхний хагас жилд мэдүүлэг буцаан зассан байдлыг газар хороодоор авч үзвэл Улаанбаатар хот дахь гаалийн газар, Дорнод дахь гаалийн газар, Увс дахь гаалийн газар, Баян-Өлгий дэх гаалийн газар, Орхон дахь гаалийн газар болон Дархан уул аймаг дахь гаалийн газрын мэдүүлгийн тоо өссөн байхад, Замын-Үүд дэх гаалийн газар, Сэлэнгэ дэх гаалийн газар, Чингис хаан		
--	--	--	--	---	--	--

				олон улсын нисэх буудал дахь гаалийн газар болон Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын буцаан засварласан мэдүүлгийн тоо буурсан байна. 2024 оны эхний хагас жилд гаалийн мэдүүлэг бүрэн баталгаажсаны дараа "гааль зөвшөөрөв" төлөвөөс буцаан засварласан байдлыг газар хороодоор нь харьцуулж харахад 1371 мэдүүлгийн дийлэнх хувийг буюу 52.95%-ийг УБГГ-ын мэдүүлэг эзэлж байна. Харин хамгийн бага хувийг ГЕГ болон Завхан дахь гаалийн хорооны мэдүүлэг тус тус эзэлж байна. "Гааль зөвшөөрөв" төлөвөөс 2023 оны эхний хагас жилд буцаан зассан 1977 мэдүүлэг нь тухайн оны нийт бүрдүүлэлтийн 1.35%-ийг эзэлж байсан бол 2024 онд зассан 2206 мэдүүлэг нь нийт бүрдүүлэлтийн 1.10%-ийг эзэлж байна. Энэ нь 2024 оны эхний хагас жилд "гааль зөвшөөрөв" төлөвөөс буцаан заасан мэдүүлгийн тоо 229 мэдүүлгээр өссөн боловч нийт бүрдүүлэлтэнд эзлэх хувь нь 0.25%-иар буурсан сайн үзүүлэлттэй байна. "Гааль зөвшөөрөв" төлөвөөс мэдүүлэг буцаан засах алдааг багасгах зорилгоор дараах ажлуудыг зохион байгуулж байна. Үүнд: - Долоо хоног болгоны мягмар гаригийг мэдээллийн өдөр болгон тогтмол сургалт явуулж байна. - Нийт байцаагч нарт БТКУС-ын 97 бүлгийг хуваарилан хариуцуулж, ГУБ бүр хуваарилагдсан бүлгийн мэдүүлгийн бичлэгийг хянах, бүрдүүлэлтийн мэдээнд дүн шинжилгээ хийх, шаардлагатай мэдээллээр ГУБ нарыг ханган ажиллаж байна. - БТКУС-ын зүйл 87.02, 87.03, 87.04, 87.05-д хамаарах барааны бүрдүүлэлтэнд 10-12 байцаагчийг хуваарилан, 2-3 сараар дагнуулан ажиллуулж байна.		
3.	Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт, гаалийн тариф, гарал үүслийн хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг хангуулж ажилласан байна. Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд: 1. Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилтийг холбогдох хууль тогтоож, журам, зааврын хүрээнд бүрэн хангуулан, хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд 6,449.67 сая ам.долларын статистик үнийн дүн бүхий бараанд 72 горимын кодоор 200,948 гаалийн бүрдүүлэлт хийгдсэн ба нийт 2,972.1 тэрбум төгрөгийн гаалийн болон бусад татвар, 2,006.03 сая төгрөгийн хураамжийг ногдуулан барагдуулж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Татварын дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 641.6 тэрбум төгрөгөөр буюу 27.5 хувиар, хураамжийн дүн 130.8 сая төгрөгөөр буюу 7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 401, 4011, 402, 4021, 403, 4031 горимоор гаалийн болон бусад албан татвараас чөлөөлөгдөж, дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор 322.85 сая ам.долларын статистик дүн бүхий бараа татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамрагдсан нь өмнөх оныхоос 25.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2. 2024 оны эхний хагас жилд түр горимын 11-н кодоор 89669.0 мян.ам.долларын үнийн дүн бүхий бараа, тээврийн хэрэгсэлд 3580 гаалийн мэдүүлгээр түр горимын оруулах болон гаргах бүрдүүлэлт хийгдсэн. /экспортын 381 мэдүүлэг 19825.3 мян.ам.доллар, импортын 3199 мэдүүлэг 69843.7 мян.ам.долл/ Түр горимын мэдүүлгийн хаалтыг харуулбал: - Горимын шаардлагын хугацаанд хаагдсан - 3796 - Горимын шаардлагын хугацаа болоогүй - 2292 - Горимын шаардлагын хугацаа хэтэрсэн - 16 гаалийн мэдүүлэг тус тус байна. Түр горимын хугацаа хэтэрсэн 2 ААН-ийн экспортын 2 мэдүүлэг /203, 213 горим/, 8 ААН-ийн импортын 14 мэдүүлэг /500 горим/ тус тус байгаа бөгөөд хугацаа хэтэрсэн, хугацаа нь дөхөж байгаа бүрдүүлэлтийг зохих горимд байршуулах талаар ААН-д заавар, зөвлөгөө өгч ажилласан. 3. Монгол улс, Япон улс хооронд байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэхдээ тус хэлэлцээр, түүний 1 дүгээр хавсралт болох "Монгол Улсын тарифын жагсаалт", 2 дугаар хавсралт болох "Бүтээгдэхүүний тусгай дүрэм", МУ-ын Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн гарал үүсэлтэй холбоотой 7-р бүлгийн холбогдох заалтууд, МУ-ын Засгийн газрын	2024.0 1.01- 2024.0 6.10	

					2016 оны "Импортын барааны гарал үүслийн дүрэм" батлах тухай 209 дүгээр тогтоол, Гаалийн тариф, татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлж ажилласан. Мөн Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн /АПТА/ хөнгөлөлттэй тарифтай холбоотой гаалийн бүрдүүлэлтэнд хяналт тавин ажиллаж байна.		
4.	Барааны ангилал, гаалийн үнэ, үнэлгээг үнэн зөв мэдүүлэх, тодорхойлох чиглэлээр зохион байгуулсан ажил	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах боломжийг судалж эхэлсэн байна. 2. Судалгаа, дүн шинжилгээнүүдийг гаалийн бүрдүүлэлтийн, орлогын, горимын, хөнгөлөлт чөлөөлөлтийн гэх мэт олон чиглэлээр хийж, удирдлагыг мэдээллээр ханган, бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагааг сажруулсан байна. 3. Барааны лавлах санг баяжуулж ажилласан байна.	1. Эрсдэл тооцох системд үндэслэн гаалийн үнийн хяналтыг оновчтой зохион байгуулах, гаалийн үнийн хяналтын тогтолцоонд шинэ хандлага төлөвшүүлэх ажлын хүрээнд дараах барааны үнийн хяналтыг хэрэгжүүлэхдээ шинэ систем туршиж үзсэн. - Трактор - Автобус - Суудлын автомашин - Ачааны автомашин - Тусгай зориулалтын автомашин - Мотоцикл - Чиргүүл - 84.26, 8427, 84.29, 84.30, 84.28 (Машин, механизм) Үүнийн үр дүнд бүрдүүлэлтийн цаг хугацаа буурсан, нэгдмэл шийдвэр гарна, машин, тоног төхөөрөмжийн үнийн хяналт сайжирсан, ГУБ нар тухайн мэргэшиж барааны талаарх мэдээлэл авах боломж бүрдсэн. Гаалийн үнийн хяналтын зорилгоор албан ёсны төлбөртэй сайтын мэдээлэл ашиглаж эхэлсэн. Үүнд, - Төмрийн нээлттэй биржийн цахим хуудас www.lgmi.com-т хандах 1 жилийн албан ёсны эрхийг 2024.06.21-ний өдөр ГЕГ-БАҮХ-ээс ирүүлснийг үнийн хяналтын зорилгоор ашиглаж байна - Япон улсаас импортлож байгаа ихэнх автомашины мэдээлэл олон нийтэд нээлттэй сайтаас авах боломжтой байддаг. Харин USS-ээс дуудлага худалдааны мэдээлэл нийтэд ил тод байдаггүй тул албан ёсоор нэг эрх авч үнийн хяналтын зорилгоор ашиглаж эхэлсэн. Худалдан авсан автомашины үнийн мэдээллийг төлбөртэй сайтаар шалгаж явцад 17 автомашин дээр зөрчил илрүүлэн нөхөн төлсөн татвар-19.77, сая торгуулийн дүн 10 сая төгрөг. ✓ [redacted] Toyota, Crown Hybrid автомашины Япон улсаас худалдан авсан бичиг баримтыг засварлан гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн нөхөн төлсөн татвар- 996495 зөрүү татвар шийтгэвэр 0094060, торгуулийн дүн 499399.66төг ✓ [redacted] Автомашин, суудлын, Lexus, LX570 АНУ-с импортоор худалдан авсан бичиг баримтыг засварлан гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн торгууль 5969340.7 зөрүү татвар 11,9 сая ✓ [redacted] тоот мэдүүлгээр TCNU3532194 чингэлэгт ачигдсан TRJ150-0134926 арлын дугаартай Toyota, Land Cruiser Prado автомашины Япон улсаас худалдан авсан бичиг баримтыг засварлан гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн нөхөн төлсөн татвар-2290931 торгууль 1145455,5төг ✓ [redacted] тоот мэдүүлгээр 9461 TRJ150-0132510 арлын дугаартай Toyota, Land Cruiser Prado барааны Япон улсаас худалдан авсан бичиг баримтыг засварлан гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн, Нөхөн төлүүлсэн татварын дүн 1436106 төгрөг торгууль 718053 төгрөг ✓ [redacted] тоот мэдүүлгээр TRJ150-0128330 арлын дугаартай Toyota, Land Cruiser Prado маркын автомашиныг Япон улсаас худалдан авсан бичиг баримтыг засварлан гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн, Нөхөн төлүүлсэн татварын дүн 1897711.5 төгрөг торгууль 948855.75 төгрөг ✓ 6. [redacted] тоот мэдүүлгээр ATH20-8022195 арлын дугаартай Toyota, Alphard	2024.01.01-2024.06.10	

				автомашиныг Япон улсаас худалдан авсан бичиг баримтыг засварлан гаалийн болон бусад татвар төлөхөөс зайлсхийсэн, 2. Гаалийн үнийн хяналтыг цахимжуулах ажлын хүрээнд Япон улсаас импорлож байгаа суудлын автомашины үнийн судалгаа хийсэн. Судалгаа дүн шинжилгээний үндсэн импортын суудлын автомашины гаалийн үнэлгээг автоматжуулах ажлыг ГЕГ-ын БАҮХ, МТГ-тай хамтран эхлүүлэн програмын туршилтыг хийсэн. Програмыг нэвтрүүлснээр CAIS системээс мэдүүлгийг бичиг баримтын шатанд автоматаар холбогдох шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан хянаж, тухайн иргэн, ААН-ийн гэрээний буюу хэлцлийн үнийг үндэслэн гаалийн үнийг тодорхойлох боломжтой болох юм. Хууль эрх зүйн хүрээнд програмыг нэвтрүүлэхтэй холбогдуулан ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам", ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар", ГЕГ-ын даргын 2012 оны А/30 дугаар тушаал батлагдсан "Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох заавар"-уудад тус тус холбогдох нэмэлтийг оруулах саналыг Барааны ангилал, үнэлгээний хамтран боловсруулах ажлыг хийсэн бөгөөд удирдлагуудад танилцуулж, нэгжүүдээс санал авч 2024 оны 3 дугаар улиралд програмыг нэвтрүүлхээр төлөвлөж, программд туршилт хийж байна. 3. Нийт импортын барааны 74.5%-ийг /755.3 мянган бараа/ хэлцлийн үнийн аргаар үнэлсэн бол 25.5%-ийг /259.4 мянган барааг/ бусад аргаар үнэлсэн ба бичиг баримтын бүрдүүлэлтийн үед нэмж төвлөрүүлсэн татварын дүн эхний хагас жилд 153.9 тэрбум төгрөг байна. Үүнээс үнийн мэдээллийн санд байгаа мэдээллийг үндэслэн 98.8 мянган бараа үнэлсэн ба нэмж ногдуулсан татварын дүн 54.1 тэрбум төгрөг, /ХАНЦ-3450/ /суурь 2023 онд Нийт импортын барааны 77.6%-ийг /679.1 мянган бараа/ хэлцлийн үнийн аргаар үнэлсэн бол 22.4%-ийг /195.4 мянган барааг/ бусад аргаар үнэлсэн ба бичиг баримтын бүрдүүлэлтийн үед нэмж төвлөрүүлсэн татварын дүн эхний хагас жилд 104.8 тэрбум төгрөг байна. Үүнээс үнийн мэдээллийн санд байгаа мэдээллийг үндэслэн 55.3 мянган бараа үнэлсэн ба нэмж ногдуулсан татварын дүн 38.1 тэрбум төгрөг ХАНШ -3600 / 4. Автомашины болон хил орчмын үнийн судалгааг хийж, ГЕГ-ын холбогдох нэгжээр хянуулан баталгаажуулж, гаалийн үнийг тодорхойлоход ашигласан байна. -БТКУС-ийн зүйл 87.03-д хамаарах АНУ-аас импортолж байгаа суудлын автомашины үнийн судалгааг CAIS-ийн 2023 оны бүрдүүлэлтийн мэдээ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэтэй харьцуулан хянаж, 62 барааны үнийг CAIS-ийн автомашины үнийн судалгааг хийж 1202401000002 дугаартай хавтсанд, - БТКУС-ийн Зүйл 87.04, 87.16-д хамаарах БНХАУ-аас импортлож байгаа чирэгч автомашин, чиргүүлийн үнийн судалгааг CAIS-ийн бүрдүүлэлтийн мэдээ, 2023 оны судалгааны үнэ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэ зэрэгтэй харьцуулан нийт 5 маркын 2014 оноос 2023 оны хооронд үйлдвэрлэгдсэн 154 нэр төрлийн чирэгч автомашин, 7 төрлийн 2014 оноос 2023 оны хооронд үйлдвэрлэгдсэн 63 ширхэг чиргүүлийн үнийн судалгаа хийж 01202401000003 дугаартай хавтсанд, - БТКУС-ийн зүйл 8606-д хамаарах ОХУ-аас импортолж байгаа зарим ачааны вагоны үнийн судалгааг CAIS-ийн 2023 оны бүрдүүлэлтийн мэдээ, интернетээр нийтэд зориулан тараасан зарим нэг цахим сайтын үнэ зэрэгтэй харьцуулан 28ш ачааны вагоны үнийн судалгааг хийж 012024020000001 хавтсанд байршуулан, ГЕГ-ын БАҮХ-р хянуулан баталгаажуулсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар Автомашины үнийн судалгаанд үндэслэн 16.8 тэрбум төгрөг, татвар нэмж төлүүлсэн байна. Мөн ГЕГ-ын БАҮХ-ээс өгсөн чиглэлийн дагуу БТКУС-ийн 8606-д хамаарах вагоны судалгааг хийж, CAIS системд 012024020000001 дугартай байршуулж үнийн		
--	--	--	--	--	--	--

					хяналтын зорилгоор ашиглаж байна. ГЕГ-ын даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2024.05.12-17-ны өдрүүдэд БАҮХ, ЗҮГГ-ын Гаалийн бүрдүүлэлтийн албаны албан хаагч нар болон МҮХАҮТ-ийн төлөөллийн хамт БНХАУ-ын Эрээн, Бугат хотын барилгын материал, төмөр, төмөр хийц, хүнд машин механизм, тоног төхөөрөмж, ачааны автомашины үнийн судалгаа хийхэд оролцсон. Ажлын хэсэг 206 нэр төрлийн барааны үнийн судалгааг нэгтгэхэд оролцон 0320240300002 дугаартай хавтсанд байршуулан үнийн судалгааг 2024.06.04-ний өдрөөс эхлэн үнэлгээний зорилгоор ашиглаж байна. 2024 оны хилийн үнийн судалгаанд үндэслэн эхний хагас жилд 23.6 тэрбум төгрөг, татвар нэмж төлүүлсэн байна. Судалгаа, дүн шинжилгээнүүдийг гаалийн бүрдүүлэлтийн, орлогын, горимын, хөнгөлөлт чөлөөлөлтийн гэх мэт олон чиглэлээр хийж, удирдлагыг мэдээллээр ханган, бүрдүүлэлтэд гарч байгаа алдаа дутагдалыг засч, үйл ажиллагааг сайжруулсан байна. Тайлант хугацаанд 178 удаа орлогын мэдээг татварын төрөл, гаалийн газар хороо, бүрдүүлэлтийн тоо, үнэлгээний арга /мэдүүлэг, бичлэг, иргэн, ААН/ -г гарган дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан. Мөн татварын орлогын дүн шинжилгээг 2,3, 5 сард гаргасан. 5.Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд барааны ангиллын хяналтыг хэрэгжүүлж, ангиллын луйврыг илрүүлж ажилласан байна. Бүрдүүлэлтийн явцад Барааны ангиллын код хянаж 831 бичлэгт өөрчлөлт оруулсан Гаалийн бүрдүүлэлтийн явцад 47 гаалийн мэдүүлгээр 403 горимоор мэдүүлсэн барааны ангиллын кодыг хянаж буруу мэдүүлснийг илрүүлж 400 горимын кодоор бүрдүүлэлт хийж, нөхөн төлүүлсэн татварын дүн 1,008,945,047.37 төг байна. /хүснэгт/ мэдүүлэг бүхий ХХ-ны 1901.90.00 код бүхий СҮҮН КРЕМ хэмээн мэдүүлсэн барааны ангиллын кодыг хянаж 0406.30.00 код бүхий Бяслаг байсныг илрүүлсэн. 0406.30.00 барааны гаалийн татварын тариф 15 хувь, бөгөөд нөхөн төлүүлсэн татвар 46сая төг төлүүлж ААН байгууллагыг 3сая төг торгосон. - Тарифын бус хязгаарлалттай барааны хяналт мэдүүлгээр ХХК-ны 3912.31.00 БТКУС код бүхий Натрийн карбоксиметилцеллюлоз бараанд Зөрчлийн тухай хуулийн 11.21 дүгээр зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу 0093259 дугаартай шийтгэлийн хуудсаар ХХК-ийг 3000 нэгжээр торгов. 2024.06.25 - дугаар бүхий Дийлэгчтэнгэр ХХК 3808.93.00 код бүхий Гербицид зэрэг шавьж устгагч зэрэг барааны лицензнээс илүү бараа мэдүүлснийг Тухайн мэдүүлгээс Диастар, ВР - 20 л, Азорит, СК - 20 л тус тус импортлох лицензгүй нэвтрүүлсэн зөрчлийг 2024 оны 06-р сарын 12-ны өдөр 15 цаг 32 минутад бүрдүүлэлтийн нэгдсэн төвийн бичиг баримтын байцаагчаас засварт буцааснаар илрүүлэн ЗХБ-ийн дугаар 157, шийтгэлийн хуудас №0090671, ЗТХ 11.21 зүйлүүн 11 дэх хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийг 1000 нэгжээр торгов тухайн 40 л бараа бүтээгдэхүүнийг хураан авч шийдвэрлэв. Бусад бараа бичиг баримтын зөрчилгүй, биет үзлэгээр зөрчилгүй. Тусгай зөвшөөрлийн эх хувиас хасалт хийсэн. 6. Барааны бичиглэл ижилсгэх чиглэлээр гарын авлага гаргаж, нэг болон ижил төрлийн зарим барааны бичиглэлийг жигдрүүлэн холбогдох судалгаа, дүн шинжилгээг хийсэн байна. Гаалийн бүрдүүлэлтийн мэдээллийг шалгах явцад зарим барааны мэдээлэл дутуу, буруу оруулсанаас хамаарч бүрдүүлэлтийн явцад хүндрэлтэй байсан тул БНХАУ-д үйлдвэрлэгдсэн суудлын автомашины vin17.com сайтаар арлын дугаараар хайлт хийхэд техникийн үзүүлэлт лавлах санд бүрэн оруулах, мөн 87.05, 84, 85, болон 90 дүгээр бүлэгт хамаарах барааны бичиглэлийн талаар 01-8/2037 тоот албан бичгээр ГБМ нарт чиглэл хүргүүлсэн. 8. Барааны лавлах санг баяжуулж ажилласан байна. Автомашины бичиглэлийг ижилсгэх чиглэлээр эхний хагас жилд ГБМ-ээс ирүүлсэн 6 оноосон нэр, 197 үйлдвэрлэгч, 69 хөдөлгүүрийн багтаамж, 1747 модель, 1124 кузовын мэдээлэл нэмж лавлах		
--	--	--	--	--	---	--	--

					санг баяжуулсан. 2024 оны эхний хагас жилд 161 оноосон нэр, 1122 үйлдвэрлэгч, 1081 хөдөлгүүрийн багтаамж, 12790 моделийн төрөл, 8862 кузовын төрлийн мэдээллийг гаалийн бүрдүүлэлтэд ашиглаж байна. Үүний үр дүнд барааны бүр төрлийн автомашин бичиглэл ижилсэн, судалгаа дүн шинжилгээ болон бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа буурсан.		
Зорилт 4: “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1.	Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бичиг баримтын бүрдүүлэлтийн үе шатанд ирсэн өргөдөл, гомдлыг холбогдох хуульд заасан хугацаанд нь бүрэн шийдвэрлэсэн байна. 2. Шийдвэрийн мэдээллийг кайс системийн маргаан шийдвэрийн сан, дуудлагын төвийн шийдвэрлэх жагсаалтад бүрэн оруулсан байна. 3. Бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУБ нарыг чадавхижуулах чиглэлд 5 хүртлэх удаа сургалт зохион байгуулсан байна.	Монгол Улсын Гаалийн тухай хууль, бусад холбогдох эрх зүйн актуудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелүүлж, үр дүнг тайлагнан ажилласан. Нэг. Өргөдөл, гомдол, маргааныг шийдвэрлэсэн байдал: Тайлант хугацаанд Бүрдүүлэлтийн цахим төв нь бичиг баримт хариуцан ажиллаж байгаа ГУБ нарыг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр 6 баг болгон хувааж нэг сарын хугацаатайгаар барааны ангилал үнэ үнэлгээний хяналт, гомдол маргааныг шийдвэрлэн ажиллаж байна. Гаалийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу ГУБ шийдвэрт гаргасан гаалийн үнэ үнэлгээтэй холбоотой 359 гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Дээр дурдсан 359 үнэ үнэлгээтэй холбоотой гомдолоос анхан шатны шийдвэрийг хэвээр үлдээсэн, гомдлыг хангахаас татгалзсан 275 шийдвэр гаргасан байна. Энэ шийдвэрийн үр дүнд 6.7 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Харин ГУБ шийдвэрийг бүхэлд нь эсхүл холбогдох хэсгийг хүчингүй өөрчилсөн 84 шийдвэр гаргасан байна. Дээрх бүх гомдлыг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасан хугацаанд хянаж шийдвэрлэсэн. Гомдол мэдээллийн үтасны талаар Тайлант хугацаанд тус төвийн гомдол санал хүлээж авах 70001280 утсанд нийтдээ давхардсан тоогоор 5919 дуудлага ирснээс 5875 гомдол хүсэлтийг шивж бүртгэсэн байна. Үүнээс: • Удаад байна, үнэлгээ хийж өгнө үү - 616 дуудлага • Мэдүүлэг баталгаажуулж өгнө үү - 101 дуудлага • Татвар, үнэлгээ өндөр – 700 дуудлага • ББГУБ солих - 453 дуудлага • Мэдүүлэг засварт буцаах - 238 дуудлага • Зөвлөгөө, мэдээлэл өгсөн - 175 дуудлага • ББГУБ-тай холбож өгнө үү - 372 дуудлага	2024.01.01-2024.06.10	

					• Мэдүүлэг буцааж өгнө үү, чат харна уу - 95 дуудлага • Гомдол гаргах талаар - 254дуудлага • БЦТ-д хамааралгүй асуудлаар хандах, хууль журмын хэрэгжилтийн талаар мэдээлэл зөвлөгөө авах болон бусад асуудлаар хандсан - 2871 дуудлага <u>Цахим хаягаар гомдол, санал хүлээж авсан талаар:</u> 2024 оны 1 сарын 01-ний өдрөөс 6 сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд https://mail.gov.mn/ цахим хаягаар ирсэн санал хүсэлт, гомдол маргааныг хүлээн авч CERP програмд бүртгэж, шийдвэрлэн, тухай бүр хаалт хийж ажилласан. Дээрх хугацаанд 1098 мэйл ирснээс 554 хүсэлт, 544 гомдол ирүүлсэн байна. Үүнээс: ✓ Үнэ үнэлгээ, ангилалтай холбоотой 544 гомдлыг нягтлан шалгаж, 366 гомдолд БТКУС-ын шийдвэр гаргасан. ✓ Аж ахуй нэгжийн гаалийн бүрдүүлэлттэй хамааралтай хүсэлт 820, иргэнтэй холбоотой 278 майлд хариу өгөн хүсэлт, гомдлыг цаг тухай бүр шийдвэрлэн ажилласан. <i>Хоёр. Шийдвэрийн мэдээллийг кайс системийн маргаан шийдвэрийн сан, дуудлагын төвийн шийдвэрлэх жагсаалтад бүрэн оруулсан байдал:</i> Тайлант хугацаанд үнэ үнэлгээ, ангилалтай холбоотой 544 гомдлыг нягтлан шалгаж, 366 гомдолд шийдвэр гарган кайс системийн маргаан шийдвэрийн санд тухай бүр бүртгэн ажилласан. Нийт 366 гомдлыг судлан, 366 маргааны шийдвэр гаргасан. • Аж ахуй нэгжийн гаалийн бүрдүүлэлттэй хамааралтай хүсэлт-252 • Иргэний гаргасан гомдол - 114 • Бусад албан хүсэлтийг аж ахуй нэгж, иргэдтэй утсаар холбогдон шийдвэрлэсэн. <i>Гурав. Алдаатай мэдүүлгийг илрүүлж засаж ажилласан талаар:</i> Алдаатай 557 мэдүүлгийг илрүүлж засуулсан. Алдааны төрлөөр дараах байдалтай байна. ✓ Барааг илгээгч, хүлээн авагчийн мэдээлэл-20 ✓ Барааны нэр, марк, зориулалт, Барааны код /Унификация/ -117		
--	--	--	--	--	--	--	--

				✓ Горим, хэлцэл, хөнгөлөлтийн код -73 ✓ Дагалдах бичиг баримт - 81 ✓ Нэгж үнэ, тоо хэмжээ, цэвэр бохир жин, даатгал, тээврийн зардал -156 ✓ Тариф, гарал үүсэл- 13 ✓ Татвар хураамж, ханш, валютын код -15 ✓ Тээврийн хэрэгсэл, барааны байршил – 38 ✓ Улсын код, нэр – 44 Дээрх алдаануудыг сүлжээгээр ГЕГ-аас засварт буцаалган алдаануудыг засуулж зохих төлөвт оруулан 11,165,574 төгрөгийн татварыг улсын төсөвт нэмж төлүүлэн ажилласан. Гурав.Бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУБ нарыг чадавхижуулах чиглэлээр: -ГЕГ-ын даргын 2012 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн А/30 "Заавар батлах тухай" тушаал гаалийн бүрдүүлэлтэд гарч буй нийтлэг алдааны талаар нийт ГУБ, ГУАБ нарт Бүрдүүлэлтийн цахим төвийн ГУАБ Ш.Наранцэцэг, ГУАБ Д.Бурмаа нар сургалт зохион байгуулсан - Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3 дахь хэсэг, мөн хуулийн 10 дугаар зүйл, бараа нийлүүлэх нөхцлийг гаалийн бүрдүүлэлтэд хэрхэн ашиглах талаар гаалийн итгэмжлэгдсэн зөвлөх С.Норжинсүрэнг урьж хичээл заалгасан. Сургалтанд нийт ГУБ, ГУАБ нар хамрагдсан. - 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдөр гаалийн зуучлагч аж ахуйн нэгж, байгууллага, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн болон зуучлагч нарт Гаалийн Бүрдүүлэлтийн Цахим Төвөөс " Гаалийн бүрдүүлэлтэд анхаарах асуудлууд" сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 100 гаруй аж ахуй нэгжийн 200 гаруй Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нар хамрагдсан. Тус сургалтыг гаалийн итгэмжлэгдсэн зөвлөх С.Норжинсүрэнг урьж ГУАБ Д.Бурмаа зохион байгуулсан. - Галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн талаар ЦЕГ-ын галт зэвсгийн сургагч багш цагдаагийн ахмад Т.Дашцэрэвийг урьж сургал хийсэн нийт ГУБ,ГУАБ нар хамрагдсан. - БТКУС-ын 70-р бүлэг "Шил ба шилэн эдлэл" - ГУАБ Пунсалдулам, ГУБ Ганбат нарын суудлын машиныг үйлдвэрлэсэн он сарыг хэрхэн шалгах, гаалийн нэгж үнийг хэрхэн тогтоох - ГУАБ Бурмаа БТКУС-ын 90.18, 90.19, 90.21,90.22 зүйлд хамрагдах барааг зөв тодорхойлох		
--	--	--	--	---	--	--

					- Замын хөдөлгөөний аюулгүй байдал, чирэгч, чиргүүлийн стандарт - ГУАБ Г.Сономцэвээн "Японы гаалийн туршлагаас" - БАҮХ-ээс чирэгч, чиргүүл, уул уурхайн тоног төхөөрөмж, барилгын материал ангиллаар гаалийн үнэлгээн дээр хийсэн дүн шинжилгээ - БЦТ-ийн үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд гэх мэтчилэн олон сургалтуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 540 алба хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэн ажилласан байна.		
2.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	ГЕГ-ын мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод 3 ажлыг тусгаж оруулан, батлуулахыг үүрэг болгосон. Үүрэг болгосон 3 ажлын 2 дугаарт нь "Улсын чанартай томоохон төсөл, арга, хэмжээний хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх барааны ангиллын кодыг тодорхойлох" гэж заагдсан ба бүрдүүлэлтийн цахим төвийн алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусган, батлуулахаар албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт хүргүүлээд байна. Дээрх ажлын хүрээнд бүрдүүлэлтийн цахим төвөөс ГЕГ-ын БАҮХ-тэй хамтран "Улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээ"-ний хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх 3 төсөл, арга хэмжээний 1117 барааны ангиллын кодыг тодорхойлон ажиллалаа. Үүнд: - Засгийн газрын 2024.01.25-ны өдрийн 37 дугаар тогтоолоор [REDACTED] ХХК-ийн Говь-Алтай аймгийн Тайшир сумын дөрвөлжин шохойн чулууны ордыг түшиглэн байгуулах шохойн үйлдвэрийн бүтээн байгуулалтад зориулагдан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх ажлын хүрээнд тус компанийн БНХАУ-ын Chengdu design and research institute of building materials industry Co.ltd компанитай байгуулсан TSENGAZAR/CDI/2021/001 гэрээний дагуу нийт 7 үнийн нэхэмжлэхийн 78 бараа болон задаргаа 506 барааны ангиллын кодыг тодорхойлсон. - Монгол Улсын ЗГ, ГЕГ [REDACTED] ХХК-ийн хооронд байгуулах 3 талд гэрээний хавсралтыг 78 нэр төрлийн тоног төхөөрөмж, барааг 506 нэр болгон задлаж ангилсан жагсаалт хавсралтыг бэлтгэв. Хавсралт батлагдан гаалийн бүрдүүлэлт хийгдэж байна. - Төвийн бүсийн эрчим хүчний системийн тав дахь эх үүсвэр буюу Төв аймгийн Баян сумын нутагт баригдах 300 МВТ-ын суурилагдсан хүчин чадалтай цахилгаан станцын барилга угсралтын ажилд зориулан импортоор оруулж ирэх тоног төхөөрөмж, бараа материалд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх ажлын хүрээнд үндсэн гүйцэтгэгч Цэцэн майнинг энд энержи ХХК-ийн оруулж ирэх нийт 1665 барааны жагсаалтаас 491 барааны ангиллын кодыг	2024.01.01-2024.06.10	

					тодорхойлов. 3. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын нутагт баригдах 50 МВТ-ын суурилагдсан хүчин чадалтай цахилгаан станцын барилга угсралтын ажилд зориулан импортоор оруулж ирэх тоног төхөөрөмж, бараа материалд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх ажлын хүрээнд үндсэн гүйцэтгэгч Райд монголиа ХХК-ийн эхний шатны оруулж ирэх нийт 120 барааны БТКУС кодыг тодорхойлсон.		
3.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгж илт, гүйцэтг элээр	-	1. Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлж ажилласан талаар хугацаанд нь тайлагнасан байна. 2. Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна. 3. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийг сайжруулах, хөгжүүлэх санал боловсруулж чиглэл хариуцсан нэгжид танилцуулж, шийдвэрлүүлсэн байна.	Бүрдүүлэлтийн цахим төв нь үйл ажиллагаандаа ГТХ, ГТГТХ-иудыг мөрдлөгө болгон ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд импортын 198143 гаалийн мэдүүлгээр гаалийн бичиг баримтын бүрдүүлэлтийг хийсэн байна. Бичиг баримтын шалгалт хийх явцдаа ГТХ, ГТГТХ зөрчсөн нийт 55 зөрчлийг илрүүлэн Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан Зөрчлийн тухай хуулийн 6 зүйлчлэлээр 66,15 сая төгрөгөөр торгож, 19,6 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлэн нийт 85,74 сая төгрөгийг төлүүлсэн байна. Энэ нь 2023 оны мөн үеэс зөрчлийн тоо 9 буюу 19,57 хувь, торгуулийн дүн 22,32 сая төгрөг буюу 50,93 хувь, нөхөн төлүүлсэн татварын дүн 11,94 сая төгрөг буюу 156,11 хувиар тус тус нэмэгдсэн байна. Төвийн болон ТЖАХ-ийн төлөвлөгөө болон биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн батлуулж, дүгнүүлэн ажилласан. Үүнд: - ГЕГ-ын ЗУГ-аас өгсөн чиглэлийн дагуу ГЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уяалдуулан Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Бүрдүүлэлтийн цахим төвийн даргын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлэн батлуулсан. Мөн нийт ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГХЭГ-ын даргын 2023 оны 98 дугаар тушаалын хүрээнд боловсруулах ажлыг зохион байгуулан, баталсан. - Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024 оны 1-р улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ГЕГ-ын ЗУГ-аас өгсөн чиглэлийн дагуу 14 ажлын хүрээнд (шалгуурт тусгагдсан) Word програм дээр хүснэгтлэн хийж, ЗУГ-т хугацаанд нь хүргүүлсэн. - ГЕГ-ын ЗУГ-аас өгсөн чиглэлийн дагуу ТЖАХ-ийн эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ЗГ-ын хэрэг эрхлэх даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "ТЖАХ-ийн гүйцэтгэлийн тайлангийн загварын дагуу тайлагнан нэгжийн даргаар дүгнүүлэн ГЕГ-ын ЗУГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Мөн дээрх тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан "ТЖАХ-ийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас"-ын хамт тус бүр нь 2 хувь үйлдэн хугацаанд нь ЗУГ-т хүргүүлсэн. 1. Гаалийн бүрдүүлэлт, холбогдох хууль тогтоомж, журам, зааврыг боловсронгуй болгоход санал санаачлагатай ажилласан байна. Гаалийн бүрдүүлэлтийг боловсронгуй болгох, үнийн хяналтыг цахимжуулах ажлын хүрээнд Япон улсаас импорлож байгаа суудлын автомашины үнийн судалгаа хийсэн. Судалгаа дүн шинжилгээний үндсэн импортын суудлын автомашины гаалийн үнэлгээг автоматжуулах ажлыг ГЕГ-ын БАҮХ, МТГ-тай хамтран эхлүүлэн програмын туршилтыг хийсэн. Програмыг нэвтрүүлснээр CAIS системээс мэдүүлгийг бичиг баримтын шатанд автоматаар холбогдох шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан хянаж, тухайн иргэн, ААН-ийн гэрээний буюу хэлцлийн үнийг үндэслэн гаалийн үнийг тодорхойлох боломжтой болох юм. Хууль эрх зүйн хүрээнд програмыг нэвтрүүлэхтэй холбогдуулан дараах заавар, журмуудад	2024.01.01-2024.06.10	

				холбогдох нэмэлт, өөрчлөлтийн оруулахаар Барааны ангилал, үнэлгээний хэлтэстэй хамтран боловсруулах ажлыг хийсэн ба ГЕГ-ын холбогдох нэгжүүдээс санал авч, ГЕГ-ын удирдлагуудад танилцуулж 2024 оны 3 дугаар улиралд нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Үүнд: - ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам", - ГЕГ-ын даргын 2016 оны А/82 дугаар тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Гаалийн хилээр нэвтрүүлэх барааны мэдүүлгийг шалгах заавар", - ГЕГ-ын даргын 2012 оны А/30 дугаар тушаал батлагдсан "Импортын барааны гаалийн үнийг шалгах, гаалийн үнийг тодорхойлох заавар" ГЕГ-ын даргын 2024 оны А/103 дугаар тушаалаар "Алтан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах" ажлын хэсэг байгуулагдсан ба ГЕГ-ын ХНХ-ийн даргын 2024.03.12-ны өдөр баталсан "Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөө"-ний дагуу дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээ. Үүнд: - ГЕГ-ын Бүрдүүлэлтийн цахим төвийн 4, гаалийн газар, хорооны бүрдүүлэлтийн албаны даргын 1, нийт 5 албан тушаалын тодохойлтыг шинээр, - Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн 5, гаалийн газар, хорооны бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУАБ-1, ГУБ-1, нийт 7 албан тушаалын тодорхойлолтыг тус тус өөрчлөлт оруулан хийж ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн. /ажлын хэсгийн вайбер груп/ - Албан тушаалын тодорхойлолтын харицуулалтыг 2 удаа хийж, ажлын хэсгийн хариуцсан албан тушаалтануудад хугацаанд нь хүргүүлсэн. /ажлын хэсгийн вайбер груп/ - Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу ШХТ, ЭУХ, ХБГ-ын эцсийн байдлаарх албан тушаалын тодорхойлолтын төслүүдийг хянан, ШХТ-ийн дарга Ц.Хатанболд, ЭУХ-ийн дарга Д.Цэндсүрэн, ХБГ-ын Д.Ариунцэцэг нарт танилцуулан гарын үсгээр баталгаажуулан тогтоосон хугацаанд нь ажлын хэсэгт хүргүүлсэн. /Ажлын хэсгийн вайбер груп/ - Хяналт, бүрдүүлэлтийн газраас Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга, бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч, бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод өгсөн саналыг нягтлан шалган тулгалт хийж, хариуг нь ажлын хэсгийн тогтоосон хугацаанд нь ГУБ н.Чулуунцэцэгт өгсөн. - Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралтад тусгагдсанаар ГХБГ, ЭУХ, ШХТ шинэчлэн өөрчлөх санал ирүүлсэн харъяа гаалийн газар, хорооны албан тушаалуудыг хянан баталгаажуулж ажилласан. Мөн тус төвөөс 2024 оны эхний хагас жилд журам, заавруудын төсөлд нийтдээ 7 удаа санал боловсруулан дотоод зурвасаар ГЕГ-ын холбогдох нэгжүүдэд хүргүүлэн ажилласан байна. Үүнд: - Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын журам, ёс зүйн дүрэм, сахилгын дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг 2024.05.22-ны өдрийн №66 тоот дотоод зурвасаар Хуулийн хэлтэст, - CAIS, CEPS системд оруулах өөрчлөлтийн талаарх саналыг 2024.05.09-ны өдрийн №62 тоот дотоод зурвасаар Мэдээллийн технологийн газарт, "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын төсөлд гаргасан саналыг 2024.04.01-ний өдрийн №46 тоот дотоод зурвасаар Барааны ангилал, үнэлгээний хэлтэст, "Гаалийн байгууллагаас хүүхдийн эрхийг хангах, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөө"-ний төсөлд гаргасан саналыг 2024.03.11-ний өдрийн №28 тоот дотоод зурвасаар Хүний нөөцийн хэлтэст,		
--	--	--	--	--	--	--

				• "Гаалийн улсын байцаагчид цол олгох, хураах, сэргээх, цолны нэмэгдэл хөлс олгох журам"-ын төсөлд тусгах санал гарган 2024.02.28-ны өдрийн №20 тоот дотоод зурвасаар Хүний нөөцийн хэлтэст, • "Гаалийн байгууллагын жөндөрийн эрх тэгш байдлыг хангах талаар 2024 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-нд тусгах саналыг 2024.02.14-ны өдрийн №9 тоот дотоод зурвасаар Хүний нөөцийн хэлтэст, • "2024 онд олон нийтэд сурталчлах төлөвлөгөө" боловсруулан, саналыг 2024.01.30-ний өдрийн №1 тоот дотоод зурвасаар Олон нийттэй харилцах албанд тус тус хүргүүлэн ажилласан байна. 2. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийг сайжруулах, хөгжүүлэх санал боловсруулж чиглэл хариуцсан нэгжид танилцуулж, шийдвэрлүүлсэн байна. Гаалийн бүрдүүлэлтийн автоматжуулсан системийг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр дараах саналыг гарган ГЕГ-ын Мэдээллийн технологийн газарт хүргүүлээд байна. Үүнд: • CAIS програмын зөрчил цэсэнд ГЕГ-БЦТ гэсэн сонголтыг нэмүүлэх саналыг 2024.03.21-ний өдрийн №39 тоот дотоод зурвасаар Мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. • CAIS, CEPS системд оруулах 20 өөрчлөлтийн талаарх саналыг 2024.05.09-ны өдрийн №62 тоот дотоод зурвасаар • ГУБ, ГУАБ нарт кайс програмд ажиллах эрх нээлгэх тухай хүсэлтийг 2024.05.20-ны өдрийн №65 тоот дотоод зурвасаар тус тус хүргүүлэн ажилласан байна. CAIS програмд оруулах өөрчлөлтийн тодорхой саналуудыг бэлдэж байгаа ба Мэдээллийн технологийн газрын дарга, ахлахуудтай уулзалт хийж санал бодлоо солилцон нягт хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.		
4.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Бүрдүүлэлтийн цахим төвийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, эрсдэлийг таньж тогтоосон, ангилж санд бүртгэсэн байна. Монгол улсын сангийн сайдын 2024.01.17-ны өдрийн 06 тоот "Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" тушаалаар Бүрдүүлэлтийн цахим төвийн асуудал хариуцсан дэргэдэх байгууллагын үндсэн үүрэг, чиг үүрэг батлагдсан. ГЕГ-ын даргын 2023.02.09-ний өдрийн Б/137 тоот тушаалаар төвийн дарга, 2024.03.04-ний өдрийн Б/133 тоот тушаалаар бүрдүүлэлтийн цахим төвд ажиллах алба хаагч нар тус тус томилогдон ажиллаж байна. Гаалийн улсын байцаагч нарыг мэргэшүүлэх чиглэлээр 97 бүлгийн барааг хуваарилан Бүрдүүлэлтийн цахим төвийн даргаар батлуулан хариуцсан бүлгийн барааны гаалийн бүрдүүлэлтэд холбогдох хууль тогтоомж, гаалийн бүрдүүлэлтийн судалгааг хийлгэж тусдаа хавтас үүсгэн санг бүрдүүлж байна. Мэдээллийн сүлжээ, аюулгүй байдлын чиглэлээр: Бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангах аливаа эрсдлээс сэргийлэх зорилгоор ажлын үед сүлжээ доголдох, тасрах болон цахилгаан тасарсан үед цаг минутаар нь бүртгэл хөтөлж байна. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хаагч нарыг тоон гарын үсэг авч токен ашиглаж бичиг баримтын шалгалт хийж байна. Сүүлд тус төвд шинээр ирсэн 5 албан хаагчид тоон гарын үсгийн төхөөрөмж авах талаар Мэдээллийн технологийн газарт уламжилсан. Мөн албан хаагч бүрийн нийт 56 суурин компьютерийг албан ёсны лицензтэй вирүсийн хамгаалалт суулгасан. Албан хаагч нарыг мэдлэг чадварыг дээшлүүлэх чиглэлээр: Бүрдүүлэлтийн цахим төвийн албан хаагч нарыг хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, бичиг	2024.01.01-2024.06.10	

					баримтын шалгалт хийхдээ алдаа, дутагдал гаргахгүй үүднээс долоо хоног бүрийн Мягмар гаригт өглөө 7:30 минутад Мэдээллийн цаг буюу дотооддоо сургалт, яриаг тогтмол хийж байна. Үүнд: 5. ГЕГ-ын даргын 2012 оны 2 дугаар сарын 29-ний өдрийн А/30 "Заавар батлах тухай" тушаал гаалийн бүрдүүлэлтэд гарч буй нийтлэг алдааны талаар нийт ГУБ, ГУАБ нарт Бүрдүүлэлтийн цахим төвийн ГУАБ Ш.Наранцэцэг, ГУАБ Д.Бурмаа нар сургалт зохион байгуулсан 6. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2, 8.3 дахь хэсэг, мөн хуулийн 10 дугаар зүйл, бараа нийлүүлэх нөхцлийг гаалийн бүрдүүлэлтэд хэрхэн ашиглах талаар гаалийн итгэмжлэгдсэн зөвлөх С.Норжинсүрэнг урьж хичээл заалгасан. Сургалтанд нийт ГУБ, ГУАБ нар бүрэн хамрагдсан. 7. Галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгслийн талаар ЦЕГ-ын галт зэвсгийн сургагч багш цагдаагийн ахмад Т.Дашцэрэвийг урьж сургалт хийсэн нийт ГУБ, ГУАБ нар хамрагдсан. 8. БТКУС-ын 70-р бүлэг "Шил ба шилэн эдлэл" 9. ГУАБ Пунсалдулам, ГУБ Ганбат нарын суудлын машиныг үйлдвэрлэсэн он сарыг хэрхэн шалгах, гаалийн нэгж үнийг хэрхэн тогтоох 10. ГУАБ Бурмаа БТКУС-ын 90.18, 90.19, 90.21, 90.22 зүйлд хамрагдах барааг зөв тодорхойлох 11. Замын хөдөлгөөний аюулгүй байдал, чирэгч, чиргүүлийн стандарт 12. Японы гаалийн туршлагаас 13. БАҮХ-ээс чирэгч, чиргүүл, уул уурхайн тоног төхөөрөмж, барилгын материал ангиллаар гаалийн үнэлгээн дээр хийсэн дүн шинжилгээ 14. БЦТ-ийн үйл ажиллагаанд анхаарах зарим асуудлууд Тайлант хугацаанд эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх үүднээс Гаалийн ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй нягт хамтран ажиллаж байна. Мөн эрсдэлийн шалгуурын хүсэлт гаргах 1 гаалийн улсын ахлах байцаагч, 3 гаалийн улсын байцаагчийг давхар хариуцан ажиллах хувиар оруулан батлаж, ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд нь хийж хэрэгжүүлсэн ажлаас дурдвал: • Эрсдэлийн удирдлагын хэлтсийн дарга болон ГУАБ, ГУБ нараас нь 2 удаа Бүрдүүлэлтийн цахим төвийн ахлахуудад, 1 удаа нийт албан хаагчдад мэдээлэл, сургалтыг авч, албан хаагчдын мэдлэг чадварыг нэмэгдүүлсэн. • Бүрдүүлэлтийн цахим төвийн чиг үүргийн хүрээнд хууль сахилт сайн, эсхүл муу хуулийн этгээдийн судалгааг хийж, хууль сахилт сайн 8 ААН-ын эрсдэл тооцож болох мэдээллийг "Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн хүсэлт"-ийн дагуу 2 удаа гаргаж 2024.02.01-ний өдрийн №5, 2024.04.12-ны өдрийн №52 тоот дотоод зурвасуудаар тус тус Эрсдэлийн удирдлагын хэлтэст хүргүүлсэн. Бичиг баримтын шалгалт хийх явцад барааны дагалдах бичиг баримт нь хэлцлийн үнийн аргыг хэрэглэх боломжгүй алдаатай, засвартай баримтыг анзааралгүйгээр хэлцлийн үнийн аргаар үнэлсэн бүрдүүлэлтийг илрүүлэн гаалийн улсын байцаагчид санамж өгч тухайн бүрдүүлэлтийн үнэлгээг дахин хийлгэж 6'877'747.89 төгрөгийн татварыг ААН-ээр нэмж төлүүлсэн. Тус төрлийн алдааг дахин гарахгүй байх үүднээс Бүрдүүлэлтийн цахим төвийн нийт гаалийн улсын байцаагч нарт анхааруулан, сэрэмжлүүлсэн. Мөн гаалийн улсын байцаагчийн гаргасан алдаа, дутагдал тохирох арга хэмжээг авахуулахаар Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтэст 2024 оны 06-р сарын 14-ний 083 тоот дотоод зурвасыг хүргүүлсэн. Мөн бичиг баримтын шалгалт хийсэн төлөвт орсон бүрдүүлэлтийг тухайн үнэлсэн гаалийн улсын байцаагч чөлөө авсан үед ААН-ээс 7000-1280 дугаарын утсанд хандах хүлээн авагчийн мэдээллийг засах хүсэлт тавьсан ба бүрдүүлэлтийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс гаалийн улсын байцаагчийг сольж мэдүүлгийг засварт буцаан хүлээн авагчийн мэдээллийг зөв болгуулан	
--	--	--	--	--	---	--

					дахин бичиг баримтын шалгалтыг хийх явцад тухайн гаалийн улсын байцаагч бичиг баримтыг шалгалт хийхдээ хайнга хандаж хэлцлийн үнийн аргаар үнэлсэн алдааг дотооддоо илрүүлэн өөр аргаар үнэлж 13'108'155.12 төгрөгийн татварыг ААН-ээр нэмж төлүүлэн хариуцлага алдсан гаалийн улсын байцаагчид удирдлагын зүгээс анхааруулга өгч нийт ГУБ нарт тус алдааны талаар санамж сэрэмжлүүлэг өгч бичиг баримтын шалгалтын ГУБ солигдсон тохиолдолд өмнө бичсэн чат санамж, засвар буцаалтын түүх болон өмнө байсан ГУБ-аас тухайн бүрдүүлэлттэй холбоотой анхаарах асуудлыг утсаар асууж тодруулж бичиг баримтын шалгалт хийж байхыг зөвлөж зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна. Бүрдүүлэлтийн цахим төвийн 7000-1280 дугаарын утсанд ирсэн дуудлагад дүн шинжилгээ хийн бичиг баримтын шалгалт хийх хугацаа урт, гаалийн татвар өндөр бодогдсон зэрэг мэдээллүүдийг нь тусад нь сан үүсгэж хариуцлагажуулах талаар ярилцсан. Мөн гаалийн улсын байцаагч нарын сарын ажлыг дүгнэх үзүүлэлтэд ашиглаж байна. Тус төв нь Гаалийн байгууллагын системийн хэмжээнд хийгдэж буй импортын гаалийн бүрдүүлэлтэд бичиг баримтын шалгалтыг хийж байгаа бөгөөд гаалийн газар, хороодод тус тусад нь ажиллаж байсан газар, хороодын онцлог шинж чанартай, хэв маягт байсан нэг стандартад оруулж ажиллуулах, хяналтыг сайжруулах чиглэлээр шат дараалсан ажлуудыг хэрэгжүүлж байна. Мөн нэг гаалийн улсын байцаагчид ногдох бүрдүүлэлт нь харьцангуй их байгаа тул энэ үзүүлэлтийг багасгах, худалдааг хөнгөвчлөх үүднээс импортын зарим нэр төрлийн барааны гаалийн үнэлгээг өөрөө үнэлэх системийг туршилтын журмаар нэвтрүүлэх ажлыг Татвар орлогын газар, Барааны ангилал, үнэлгээний хэлтэс, Мэдээлэл технологийн газартай хамтран хэрэгжүүлэхээр программын бодлогын даалгаврыг өгч туржиж байна. Энэ нь нэг алба хаагчид ногдох гаалийн бүрдүүлэлт 10-15 хувь буурах тэр хэмжээгээр тухайн гаалийн улсын байцаагч өөрт оногдсон бүрдүүлэлтэд бичиг баримтын шалгалтыг нэмэгдүүлж хяналт шалгалтыг сайжруулах магадлалтай гэж тооцож байна. Бүрдүүлэлтийн үйл явцад эрсдэл тооцон дараах ажлуудыг судалгаа, дүн шинжилгээ хийж хяналтыг сайжруулан хариуцлага тооцохоор төлөвлөн ажиллаж байна. Үүнд: 1. Хэлцлийн үнийн арга сонгосон бүрдүүлэлтийн дамтамж, холбогдох бичиг баримтыг нягтлан шалгах, 2. Бичиг баримтын шалгалт хийсний дараа тухайн бүрдүүлэлтэд дахин бичиг баримтын шалгалт хийж татварт өөрчлөлт орсон бүрдүүлэлтийг ГУБ бүрээр нягтлан шалгах /маргаан хүчин зүйлсийг тодорхойлох,/ 3. Хамтарсан манифестийн мэдээллийг бүрдүүлэлттэй тулган шалгах, 4. Улбар шар, ногоон төлөвтэй бүрдүүлэлтийн цаг хугацаа, бичиг баримтын шалгалт, 5. Гомдол, мэдээллийн утас 7000-1280 бүртгэл, мэдээлэл		
5.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгж илт, гүйцэтг элээр	-	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Тус төвөөс ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, мэргэжлийн зөвлөл, шуурхай хуралдаанаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн, биелэлтийг нь хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлээ. Үүнд: 1. ГЕГ-ын Мэргэжлийн зөвлөлийн 2024.03.13-ны өдрийн 03/02 дугаар хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу дараах 3 ажлыг бүрдүүлэлтийн цахимт төвийн алба хаагчдын албан тушаалын тодорхойлолт шинээр боловсруулахдаа тусгах талаар ГЕГ-ын ХНХ-ийн 2024.03.14-ны өдрийн №73 тоот дотоод зурвасаар ирүүлсэн. Бүрдүүлэлтийн цахим төвийн алба хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахдаа тусгаж, төслийг албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн. Үүнд: • Барааны бичиглэлийг ижилсгэх ажлыг зохион байгуулах, барааны лавлах санг баяжуулах,	2024.01.01-2024.06.10	

				боловсронгуй болгох, - Улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээний хүрээнд гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх барааны ангиллын кодыг тодорхойлох, - Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөгөө өгөх, хариуцлага тооцох 2. ГЕГ-ын ЗББНДБ-уудтай дотоод зурвасаар харилцсан байдалыг харуулвал: - Явсан – 90, - Ирсэн – 72 дотоод зурвас байна. Ирсэн 72 дотоод зурвасаас хариутай 36, хариугүй 36 байна. Хариутай 36 дотоод зурвасын хариуг хугацаанд нь холбогдох нэгжүүдэд бүрэн хүргүүлж ажилласан байна. 3. Албан бичгийн талаар: - Бүрдүүлэлтийн цахим төвөөс явуулсан – 8, - Бүрдүүлэлтийн цахим төв хаягтайгаар ирсэн – 33 - Бусад – 20 Албан бичгээр өгөгдсөн чиглэл, зааврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 4. ГЕГ-ын ЗУГ-аас өгсөн чиглэлийн дагуу ГЕГ-ын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уяалдуулан Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Бүрдүүлэлтийн цахим төвийн даргын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь ГЕГ-ын ЗУГ-т хүргүүлэн батлуулсан. Мөн нийт ТЖАХ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулан, баталсан. 5. Бүрдүүлэлтийн цахим төвийн 2024 оны 1-р улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ГЕГ-ын ЗУГ-аас өгсөн чиглэлийн дагуу 14 ажлын хүрээнд (шалгуурт тусгагдсан) Word програм дээр хүснэгтлэн хийж, ЗУГ-т хугацаанд нь хүргүүлсэн. 6. ГЕГ-ын ЗУГ-аас өгсөн чиглэлийн дагуу ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг ЗГ-ын хэрэг эрхлэх даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "ТЖАХ-ийн гүйцэтгэлийн тайлангийн загварын дагуу тайлагнан нэгжийн даргаар дүгнүүлэн ГЕГ-ын ЗУГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Мөн дээрх тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан "ТЖАХ-ийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний хуудас"-ын хамт тус бүр нь 2 хувь үйлдэн хугацаанд нь ЗУГ-т хүргүүлсэн.		
--	--	--	--	--	--	--

					7. Нийт алба хаагчдыг үүрэгжүүлэх, мэдээ, тайлан гаргах, үүрэг даалгаврын биелэлтийг хангах, удирдлагыг мэдээллээр хангах, хариуцлага хяналтыг нэмэгдүүлэхээр ажлын хуваариудыг хийж нийт алба хаагч нарт танилцуулан, баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнд: • ГУАБ нарын хариуцсан ажлын хуваарийг /БТКУС, газар хороогоор хуваарилсан/, • ГУАБ нарын 2024 оны 2 дугаар улирлын амралтын өдөр ажиллах, нөхөж амрах болон сунаж ажиллах хуваарийг, • ГУАБ, ГУБ нарын давхар хариуцсан ажил үүргийн хуваарийг /байнга хариуцан ажиллах 20 ажил үүргийг нийт алба хаагчдад хуваарилсан/, • ГУБ нарын хариуцсан барааны бүлгийн хуваарийг /БТКУС-ыг нийт ГУБ нарт хуваарилан тогтмол хийж байх 5 ажил үүрэгтэйгээр/ тус тус батлан гаргаж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 8. СЕРП програмын үүрэг даалгавар цэсээр ёс зүйн дэд хорооны хуралдаанаас өгсөн 1 , ХШҮДАГ-аас өгөгдсөн 2 зөвлөмж, ЗУГ-аас өгөгдсөн 2 үүрэг даалгаврын биелэлтийг ханган, хугацаанд нь оруулан дүгнүүлэн ажилласан. Хэрэгжүүлээгүй болон хугацаа хоцроосон биелэлт байхгүй.		
6.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1.Алба хаагчдын ажлын цагийг бүрэн бүртгэж, хяналт тавьсан байна. 2. Ажлын цаг ашиглалт 90 хувиас доошгүй байна.	Монгол улсын сангийн сайдын 2024.01.17-ны өдрийн 06 тоот "Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" тушаалаар Бүрдүүлэлтийн цахим төвийн асуудал хариуцсан дэргэдэх байгууллагын үндсэн үүрэг, чиг үүрэг батлагдсан. ГЕГ-ын даргын 2023.02.09-ны өдрийн Б/137 тоот тушаалаар төвийн дарга 1, 2024.03.04-ны өдрийн Б/133 тоот тушаалаар бүрдүүлэлтийн цахим төвд ажиллах 53-н алба хаагч нар тус тус томилсон. ГЕГ-ын дэргэдэх Бүрдүүлэлтийн цахим төв нь тайлант хугацаанд нийт 60-н албан хаагчтайгаас төвийн дарга 1, гаалийн улсын ахлах байцаагч 6, гаалийн улсын байцаагч 51, ТҮ-2 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа Даваа-Ням гариг, 09-20 цаг хүртэл тасралтгүй 19-н газар хорооны гаалийн бүрдүүлэлтийг онлайнаар хийж гүйцэтгэдэг. Тайлант хугацаанд БЦТ-өөс 2 ГУБ шилжин явж, 5 ГУБ шилжин ирсэн. Харьяалах гаалийн газар хорооруу буцаж ажиллахаар ГУБ Т.Хонхонцэцэг, Э.Өнөболд нар 2024.03.04 шилжсэн. Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар тус тус дараах албан хаагч нар томилогдон ирсэн. - 2024.03.04 өдрийн ГЕГ-ын даргын Б/133 дугаар тушаалаар ГУБ Б.Жаргал, С.Сэлэнгэ нар, - 2024.03.14 өдрийн ГЕГ-ын даргын Б/189 дүгээр тушаалаар ГУАБ О.Шагдар, - 2024.03.29-ны өдрийн ГЕГ-ын даргын Б/237 дугаар тушаалаар ГУБ С.Цэрэннадмид, - 2024.05.14-ны өдрийн ГЕГ-ын даргын Б/346, Б/347 дугаар тушаалаар ГУБ Н.Цэрэндолгор, Э.Хатантуул нар, - 2024.06.17 өдрийн ГЕГ-ын даргын Б/438, Б/439 дүгээр тушаалаар ТҮ-ний албан хаагчаар Б.Мөнхболор А.Мандхай нар томилогдсон. Тайлант хугацаанд нийт 4734 өдөр, 37872 цаг ажиллахаас: - Ажилласан 4163 өдөр, 33304 цаг, - 2024 оны ээлжийн амралт авсан ТТ 21 албан хаагч, 364 өдөр, 2912 цаг, - Ажил таслалт 1 өдөр, 8 цаг,	2024.01.01-2024.06.10	

				- Өвчтэй ТТ 9 албан хаагч, 40 өдөр, 320 цаг, - Хүүхэд асрах чөлөөтэй ТТ 1албан хаагч 82 өдөр, 656 цаг, - ГЕГ-ын даргын 2024.06.06-ны өдрийн Б/428 дугаар тушаалаар 1 сарын цалинтай чөлөө ТТ 1 /Ц.Энхжаргал/ албан хаагч 19 өдөр, 152 цаг, - Илүү цаг 6229 Ажлын цаг ашиглалт 4734 өдөр, 37872 цаг ажиллахаас ажилласан 4163 өдөр, 33304 цаг, хүүхэд асрах чөлөөтэй ТТ 1албан хаагч 82 өдөр, 656 цаг, 1 сарын цалинтай чөлөө ТТ 1 албан хаагч 19 өдөр, 152 цаг, 2024 оны ээлжийн амралт авсан ТТ 21 албан хаагч, 364 өдөр, 2912 цаг буюу ажлын цаг ашиглалт 99% байна. Ажлын цаг ашиглалтыг хянаж, цаг ашиглалтыг сайжруулахын тул ГУАБ, ГУБ нарын ирцийг өдөр бүр бүртгэж, хоцорсон ГУАБ, ГУБ нарт анхааруулга, сануулга өгсөний үр дүнд ажлын цаг ашиглалт сайжирсан.		
--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	"Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралт"-д заагдсаны дагуу хуваарилагдсан АТГ төслийг боловсруулан ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн байх.	Хэрэгжилт, гүйцэтгэл зэр	-	Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	ГЕГ-ын даргын 2024 оны А/103 дугаар тушаалаар "Алтан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах" ажлын хэсэг байгуулагдсан ба ГЕГ-ын ХНХ-ийн даргын 2024.03.12-ны өдөр баталсан "Албан тушаалын тодорхойлолт шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөө"-ний дагуу дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ. Үүнд: • ГЕГ-ын Бүрдүүлэлтийн цахим төвийн 4, гаалийн газар, хорооны бүрдүүлэлтийн албаны даргын 1, нийт 5 албан тушаалын тодохойлолтыг шинээр, • Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн 5, гаалийн газар, хорооны бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан ГУАБ-1, ГУБ-1, нийт 7 албан тушаалын тодорхойлолтыг тус тус өөрчлөлт оруулан хийж ажлын хэсэгт хугацаанд нь хүргүүлсэн. /ажлын хэсгийн вайбер груп/ • Албан тушаалын тодорхойлолтын хариуцлалтыг 2 удаа хийж, ажлын хэсгийн хариуцсан албан тушаалтануудад хугацаанд нь хүргүүлсэн. /ажлын хэсгийн вайбер груп/ • Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу ШХТ, ЭУХ, ХБГ-ын эцсийн байдлаарх албан тушаалын тодорхойлолтын төслүүдийг хянан, ШХТ-ийн дарга Ц.Хатанболд, ЭУХ-ийн дарга Д.Цэндсүрэн, ХБГ-ын Д.Ариунцэцэг нарт танилцуулан гарын үсгээр баталгаажуулан	2024.01.01-2024.06.10	

					тогтоосон хугацаанд нь ажлын хэсэгт хүргүүлсэн. /Ажлын хэсгийн вайбер груп/ • Хяналт, бүрдүүлэлтийн газраас Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга, бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын ахлах байцаагч, бичиг баримтын бүрдүүлэлт хариуцсан гаалийн улсын байцаагчийн албан тушаалын тодорхойлолтод өгсөн саналыг нягтлан шалган тулгалт хийж, хариуг нь ажлын хэсгийн тогтоосон хугацаанд нь ГУБ н.Чулуунцэцэгт өгсөн. • Ажлын хэсгийн хийх ажлын төлөвлөгөөний хавсралтад тусгагдсанаар ГХБГ, ЭУХ, ШХТ шинэчлэн өөрчлөх санал ирүүлсэн харъяа гаалийн газар, хорооны албан тушаалуудыг хянан баталгаажуулж ажилласан.		
2.		Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.		2024.01.01-2024.06.10	

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Сургалтад хамрагдсан байна.	Бүрдүүлэлтийн цахим төвийн алба хаагчид 7 хоног бүрийн Мягмар гарагт өглөө 8 цагаас мэдээ, мэдээллийн цагийг уламжлал тогтмол зохион байгуулж, бусад байгууллагаас мэргэжилтэн урьж авчиран сургалт явуулж байна. Тайлант хугацаанд БЦТ-өөс зохион байгуулсан сургалтуудад давхардсан тоогоор 540 орчим алба хаагч хамрагдсан байна.	2024.01.01-2024.06.10	
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ сайжруулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Хууль эрх зүйн мэдлэг сайжирч, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн байна.	Үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр гарсан холбогдох хууль, тогтоол, журам, заавартай танилцан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.	2024.01.01-2024.06.10	

ТАЙЛАН ГАРГАСАН:

БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН
ДАРГА

(Албан тушаал)


..... /Э.Лхагвасүрэн /
(Нэр, гарын үсэг)

2024 06 10
(Огноо)

804

**БҮРДҮҮЛЭЛТИЙН ЦАХИМ ТӨВИЙН ДАРГА ЭРДЭНЭХҮҮГИЙН ЛХАГВАСҮРЭНГИЙН 2024
ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Бүрдүүлэлтийн цахим төв

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		63,2

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах		12.5
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх		12.5
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:			12.5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	15
2.	Удирдан зохион байгуулах	14
3.	Асуудал шийдвэрлэх	14
4.	Манлайлах	14
5.	Багаар ажиллах	14
6.	Харилцаа	14
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	—
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		14.2

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	63.2
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	12.5

3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	14.2
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	—
Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		89.9

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Бүрдүүлэлтийн цахим төвийн дарга

Төсвийн шууд захирагч:

(Р.Отгонжаргал)

2024.12.19 (огноо)

Нэгжийн дарга:

(Э.Лхагвасүрэн)

2024.12.20 (огноо)